



Захиалагч: УИХ-ын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБХХ "Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь" төсөл

Гүйцэтгэгч: Судалгаа, зөвлөх үйлчилгээний "Эс Ай Си Эй" ХХК

**ИТХ-ЫН САЙН ТУРШЛАГА
СУРГАМЖИЙН ТАЛААР
СУДАЛГАА ХИЙХ,
СУРТАЛЧИЛГААНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
АГУУЛГА БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР
САНАЛ ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛАХ
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ**

2020 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
БҮЛЭГ 1. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН САЙН ТУРШЛАГЫГ СУДЛАХ АРГА ЗҮЙ	4
1.1 Судалгааны зорилго	4
1.2 Хамрах хүрээ	4
1.3 Судалгааны арга	4
1.4 Сайн туршлагыг үнэлэх шалгуур үзүүлэлт	5
БҮЛЭГ 2. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН САЙН ТУРШЛАГУУД	7
2.1 Иргэдийн оролцоо ба ИТХ	7
1. Архангай аймгийн Тариат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	8
2. Завхан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	14
3. Завхан аймгийн Их Уул сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	17
4. Баянхонгор аймгийн Жаргалан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	20
5. Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	25
6. Увс аймгийн Ховд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	30
7. Хэнтий аймгийн Галшар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	32
8. Дорнод аймгийн Чойбалсан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	35
9. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	42
10. Ховд аймгийн Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	49
2.2. Нийгмийн бүлгүүдийн оролцоог зохистой хангах арга зам	52
1. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	53
2. Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	58
3. Увс аймгийн Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	63
4. Дундговь аймгийн Адаацаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	65
2.3 ИТХ-ын хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх нь	72
1. Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	73
2. Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	79
3. Завхан аймгийн Их-Уул сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	85
4. Хэнтий аймгийн Мөрөн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	88
5. Завхан аймгийн Их-Уул сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	95
6. Баянхонгор Заг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	97
2.4 ИТХ ба нийгмийн сайн сайхан байдал	102
1. Төв аймгийн Зуунмод сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	103
2. Төв аймгийн Өндөрширээт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	107
3. Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	110

4. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	116
5. Ховд аймгийн Дөргөн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	121
2.5 Байгаль орчноо хамгаалахад ИТХ-ын үүрэг	127
1. Увс аймгийн Зүүнговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	128
2. Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	135
3. Завхан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	139
2.6 ИТХ ба нутгийн өөрөө удирдах ёсны хэрэгжилт	144
1. Улаанбаатар хот Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	145
2. Төв аймгийн Алтанбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	148
3. Ховд аймгийн Мөнххайрхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	151
4. Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	153
БҮЛЭГ 3. ИТХ-ЫН САЙН ТУРШЛАГЫГ СУРТАЛЧЛАХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛГА БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ	156
1. Сайн туршлагыг хэрэгжүүлэх арга зүй	156
2. ИТХ-ын сайн туршлагыг сурталчлан түгээх санал зөвлөмж	164

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ИТХ	<i>Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал</i>
ИТХТ	<i>Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч</i>
УИХТГ	<i>Улсын Их Хурлын Тамгын Газар</i>
НҮБ	<i>Нэгдсэн Үндэстний Байгууллага</i>
НҮБХХ	<i>Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр</i>
ШХА	<i>Швейцарын Хөгжлийн Агентлаг</i>
ИНХ	<i>Иргэдийн Нийтийн Хурал</i>
БИНХ	<i>Багийн Иргэдийн Нийтийн Хурал</i>
ОНХС	<i>Орон Нутгийн Хөгжлийн Сан</i>
СХС	<i>Сум Хөгжүүлэх Сан</i>
НӨУБ	<i>Нутгийн Өөрөө Удирдах Байгууллага</i>
ЕБС	<i>Ерөнхий Боловсролын Сургууль</i>
БЗД	<i>Баянзүрх дүүрэг</i>
ЧД	<i>Чингэлтэй дүүрэг</i>
СБД	<i>Сүхбаатар дүүрэг</i>
ЗДТГ	<i>Засаг Даргын Тамгын Газар</i>
БОЭТ	<i>Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төв</i>
ЭМТ	<i>Эрүүл Мэндийн Төв</i>

БҮЛЭГ 1. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН САЙН ТУРШЛАГЫГ СУДЛАХ АРГА ЗҮЙ

1.1 Судалгааны зорилго

Энэхүү төслийн үндсэн зорилго нь “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлага, сургаамж”-ийн талаар судалж, сайн туршлагыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах санал, зөвлөмж боловсруулахад оршино. ИТХ хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд иргэд олон нийтийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх тал дээр өөр өөр байдлаар ажиллаж байгаа ч нийтээр нь дүгнэн авч үзвэл нэг бүрэн эрхийн хугацаанаас дараагийн бүрэн эрхийн хугацаанд Хурлууд ажлын үр дүн, арга туршлагын хувьд сайжран чадавхжиж байгаа нь харагдаж байна¹. Тиймээс нутгийн өөрөө удирдах байгууллагаас хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, түүний хэлбэр, арга барилыг судлах нь судалгааны үндсэн чиглэл байна.

1.2 Хамрах хүрээ

Судалгаанд Улаанбаатар хотын 9 дүүрэг, орон нутгийн 21 аймаг, 330 сумын ИТХ-ыг хамруулна.

1.3 Судалгааны арга


Судалгааны мэдээлэл цуглуулах аргыг хураангуйлан дараах зурагт харууллаа.

Зураг 1. Судалгааны арга



Уг зөвлөх үйлчилгээнд хийгдэх ажлын хүрээг бид үндсэн 2 хэсэгт дараах байдлаар хуваалаа.

Зураг 2. Зөвлөх үйлчилгээний ажлын хүрээ, хийгдэх судалгааны ажил, хүлээгдэж буй үр дүн



Судалгааны арга хэсэгт дурдсанаар ИТХ-ын сайн туршлагыг судлах, сурталчилгаа, бүтээгдэхүүний агуулга болгон хөгжүүлэх санал, зөвлөмж боловсруулах ажлыг хийж гүйцэтгэх эхний алхам нь аймаг, дүүрэг, сумын ИТХ-ын сайн туршлагад баримт бичгийн шинжилгээ хийж, судлах явдал юм. Үүний тулд сайн туршлага хэмээн үзэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлох ажлыг уг төслийн хүрээнд хийж гүйцэтгэх юм.

¹ ИТХ-ыг дэмжих тэтгэлэг- сайн туршлагын эмхэтгэл, 2016


1.4 Сайн туршлагыг үнэлэх шалгуур үзүүлэлт

ИТХ нь иргэдийн амьдралд ихээхэн нөлөөтэй хамтын шийдвэр гаргах, иргэдийн дуу хоолойг орон нутгийн бодлого, төсөв, төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлд тусгах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийг хуулиар хүлээсэн байгууллага юм.

Орчин үеийн байгууллагын зорилго, ялангуяа хүргэж буй үйлчилгээ нь иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц, үйл ажиллагааны үр дүн нь иргэдэд чухал байх, үйлчилгээ нь хүртээмжтэй, чанартай байхад чиглэж байгааг өрнө дахинд “Public Value” буюу “ард түмний үнэт зүйл”-ийг бүтээх явдал хэмээн үзэж байна. Энэ нь иргэдийн итгэлийг хүлээсэн чанар (тэгш боломжтой, хариуцлагатай, ил тод)-тай бүтээгдэхүүн, үйлчилгээ хүргэх, нийтийн сайн сайхан байдлыг бүтээх явдал бол ард түмний үнэт зүйлийг бүтээх үзэл баримтлал юм (Mark Moore, 1995) гэжээ.

Иймд ардчилсан төрийн нийтийн сайн сайхан байдал гэдэг зарчмыг томоор харах хэрэгтэй бөгөөд ИТХ нь иргэдийг сайн сайхан байдалд хүргэх төлөөллийн байгууллагыг оновчтой байдлаар удирдах, урт хугацаанд үр дүнд хүрэхэд чиглүүлэн удирдах нь чухал юм. Үүнийг энгийнээр хэлбэл, ИТХ тавьсан зорилгодоо хэрхэн хүрэхээ тодорхойлсон стратегич сэтгэлгээтэй, өнөөдрийн үйлдэл нь ирээдүйд сайн үр дагаврыг авчрах, түүнчлэн орчны өөрчлөлтөд дасан зохицох, суралцах чадвартай байх тухай ойлголт юм. Иймээс бид төслийн зорилгын хүрээнд ИТХ-уудын сайн туршлагын шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, бидний ИТХ-ын үйл ажиллагааны үр дүн нь сайн туршлага болох практикийг дүгнэн үзэхдээ Ард түмний үнэт зүйл (Public value)-ийн үзэл баримтлалыг үндэслэлээ болголоо. Ард түмний үнэт зүйлийн үзэл баримтлалын хүрээнд тодорхойлсон шалгуур үзүүлэлтийг доорх зурагт харуулав.

Зураг 3. Ард түмний үнэт зүйлийг бүтээх шалгуур үзүүлэлт



Дээрх “ард түмний үнэт зүйл” (Public value)-ийн үзэл баримтлалд үндэслэн ИТХ-уудын сайн туршлагын шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тодорхойлов.

Шалгуур үзүүлэлтийн хувьд ИТХ-ын өөрийн үйл ажиллагаа буюу институтийн чадавч бэхжүүлэх, иргэд олон нийтийн сайн сайхан байдалд чиглэсэн байх гэсэн суурь 2 ангиллын хүрээнд үндсэн 4 үзүүлэлтийн хүрээнд авч үзсэн болно. **Үүнд:**

1. ИТХ-ын хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаа нь бусад ИТХ авч хэрэгжүүлэх боломжтой байх,

2. Монгол Улсын хууль эрх зүй, үндэсний хөгжлийн бодлогод нийцсэн байх,
3. ИТХ-ын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаанд шинэ технологийг нэвтрүүлсэн байх,
4. Орон нутгийн иргэдэд ашиг тусаа өгсөн, тэдэнд хүлээн зөвшөөрөгдсөн байх.

Дээрх 4 шалгуур үзүүлэлтээр ИТХ-аас ирүүлсэн сайн туршлагын мэдээллийг үнэлэх юм. Үнэлэхдээ үзүүлэлт тус бүрийг 1-10 оноогоор /1-муу, 10-маш сайн/ үнэлнэ.

1

Иргэдийн санаа бодол ИТХ-ын шийдвэрийн үндэс суурь болох нь

2

ИТХ-ын үр нөлөөг дээшлүүлэх нь

3

ИТХ-ын хяналт зохицуулалтыг сэйжруулах нь

4

ИТХ-ын үйл ажиллагаанд нийгмийн бүлгүүдийг татан оролцуулах нь

5

Байгаль орчноо хамгаалахад ИТХ-ын оролцоо, үр дүн

6

ИТХ-ын бусад сайн туршлагауд

1. Архангай аймгийн Тариат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

“ ИРГЭДИЙН ОРОЛЦОО-БОДИТ ИДЭВХЖҮҮЛЭЛТ”

САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ



С.ӨЛЗИЙСАЙХАН, Архангай аймгийн Тариат сумын ИТХ-ын дарга.

Нутгийн удирдлагын менежментийн чиглэлээр мэргэшсэн. Архангай аймгийн Тариат сумын Мөрөн багийн Засаг даргын үүрэгт ажлыг 2012-2016 онд хийж гүйцэтгэсэн. 2012 болон 2016 онуудад сумын ИТХ-д төлөөлөгчөөр сонгогдон ажилласан. Архангай аймгийн Тариат сумын ИТХ-ын даргаар 2017 оноос ажиллаж байна.

Холбоо барих утас: 99135710, Цахим хаяг: seersosor2015@gmail.com

АГУУЛГА

Иргэдийг БИНХ-д оролцох оролцоог нэмэгдүүлэх. Иргэдийн оролцоог идэвхжүүлэх зорилгоор “Иргэн, айл өрхийн нийгмийн идэвх оролцоог үнэлж дүгнэх журам” батлан хэрэгжүүлсэн.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Архангай аймгийн Тариат сумын 7 БИНХ-д оролцох оролцоо хангалтгүй, иргэд санал бодлоо хуваалцах байдал дутмаг байсан.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Архангай аймгийн Тариат суманд оршин сууж байгаа 18-аас дээш насны иргэдийг хамруулсан.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2019 оны 03 дугаар сарын 1-ээс 2019 оны 11 дүгээр сарын 30.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

Тариат сумын 7 баг тус бүрд өрхийн тэргүүлэгчдийн нэртэй оролцооны самбар байршуулсан. Өрхийн гишүүдийн оролцооны үзүүлэлтийг өрхийн тэргүүлэгчдийн үзүүлэлтэд нэмж тооцсон. Баг бүрд иргэдийн оролцоог дүгнэх комисс байгуулагдан, өрхийн нийгмийн идэвхийг цаг тухай бүрд үнэлсэн. “Иргэн, айл өрхийн нийгмийн идэвх оролцоог үнэлж, дүгнэх журам”-ыг боловсруулан 2019 оны 2-р сарын 18-ны өдөр ИТХТ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн 19 тоот тогтоолоор батлан хэрэгжүүлсэн. Иргэдийн нийгмийн идэвх оролцоог дүгнэх самбар хөтөлж, цаашид тасралгүй үргэлжлүүлэх зорилгоор шилдэг өрхийг урамшуулж ажилласан.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- Иргэн, айл өрхийн нийгмийн идэвх оролцоог үнэлж, дүгнэх журмыг боловсруулсан,
- Иргэн, айл өрхийн нийгмийн идэвх оролцоог үнэлж, дүгнэх самбарыг сумын ИТХ-ын төсвөөс санхүүжүүлэн хэвлүүлж, 7 багийн удирдлагуудад өгч багийн төвүүд байрандаа байрлуулан, өдөр тутамдаа хөтөлж багийн иргэдэд нээлттэй мэдээлсэн,
- 2019 оны 12 сард журмын хэрэгжилтийг дүгнэж баг бүрээс нэг өрх, нийтдээ 7 өрхийг шагнаж урамшуулсан.



САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Сумын ИТХ-ын төсвөөс 1.5 сая төгрөгөөр санхүүжүүлсэн.

ХҮРСЭН ҮР ДҮН

- ИТХТ-ийн баталсан “Иргэн, айл өрхийн нийгмийн идэвх оролцоог үнэлж, дүгнэх журам”-ыг иргэдийн нийгмийн идэвх оролцоог сайжруулах, хандлагыг өөрчлөх, цаашлаад иргэдийн шууд оролцоог нэмэгдүүлэх, БИНХ болон бусад шийдвэр гаргалтад оролцдог байхад хөшүүрэг болох үүднээс туршилтаар 9 сарын хугацаатай батлан хэрэгжүүлсэн.
- 2019 онд тус сумын 7 багийн нийгмийн идэвх оролцоо сайжирч, БИНХ-ын ирц нэмэгдсэн.
- 2019 оны 5,10 саруудад хийсэн хуралд бүх багийн ИНХ-ын ирц 30-40 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Иргэд өнөөгийн аж амьдралдаа ихэнх цаг хугацааг зарцуулж, олон нийтийн үйл ажиллагаанд төдийлөн ач холбогдол өгөхгүй болсон байна. Ялангуяа анхан шатны буюу төр захиргааны байгууллагын шийдвэр болон олон нийтийн арга хэмжээнд хойрго, хариуцлагагүй ханддаг нь иргэдийн идэвх, оролцоог сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулахад бэрхшээл болж байна. Тухайн журмыг иргэдэд таниулах, хэрэгжилтийг хангуулах, үнэлж дүгнэхэд багийн түвшний албан хаагчдын үүрэг хариуцлага, санаачилга их чухал байдаг. Алба хаагчид журамд хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлдэг нь ажил явагдахад саад учруулдаг байна.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

Өрхүүдийг улирал болон жилийн ажлаар нь, татвар хураамж, олон нийтийн оролцоогоор нь дүгнэж байгаа нь маш үр дүнтэй ажил болсон. Багийн дарга бид нарын ажилд тус дэм болж байгаа. Хамгийн гол асуудал болох БИНХ –ын ирц өмнөхөөсөө эрс нэмэгдсэн байна. Өрөөнд орж ирсэн иргэд самбараа хараад хэн хэдэн удаа хуралдаа сууж, манай баг ямар түвшинд явж байна гээд л хардаг. Суман багийн засаг дарга Ю.Наранцэцэг

Иргэдийг идэвх оролцоогоор нь харьцуулан үнэлж, дүгнэх ажил нь цаг үеэ олсон үр дүнтэй ажил болсон. Тухайлбал бүх өрхийг БИНХ-д оролцсон байдал, байгаль орчноо цэвэрлэсэн байдал, зам давааны засварт оролцсон эсэхээр нь дүгнэн, үнэлгээг самбарт байршуулснаар хүмүүсийн хандлага өөрчлөгдөж байна. Миний хувьд багаас зохион байгуулж байгаа бүх олон нийтийн ажилд оролцохыг хичээдэг. Энэ хичээл зүтгэлийг маань үнэлэн 2019 оны "Багийн шилдэг" нийгмийн оролцоотой өрхөөр шагнасан. **Мөрөн багийн иргэн О.Сайнбаяр**

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Орон нутгийн иргэн, өрх бүр идэвхжиж БИНХ-ын ирц өмнөх үетэй харьцуулахад 30-44 хувиар өссөн байгаа нь иргэд өөрийн эрх, үүргийг ухамсарлаж, нийгмийн идэвхтэй байхад нөлөө үзүүлсэн.

Иргэдийн оролцоо, идэвх санаачилга сайжирч санал, бодлоо илэрхийлэх байдал нэмэгдсэнээр БИНХ, ИТХ-аас гарч буй бодлого шийдвэрүүд хэрэгжих боломж нэмэгдэхийн зэрэгцээ иргэдийн оролцоотой хяналтын тогтолцоо бий болох үндэс суурийг бий болгосон. Өөрөөр хэлбэл иргэдийн оролцоонд түшиглэсэн бодлого, шийдвэр гарах боломжтой болсон.

"Иргэн, айл өрхийн нийгмийн идэвх оролцоог үнэлж, дүгнэх журам"-ыг таниулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангах, тогтвортой байдлыг хадгалах үйл явцад багийн түвшний алба хаагчид хамтран ажилласан нь хариуцлагатайгаар хамтран ажиллах боломжийг олгож, цаашдын хамтын ажиллагаанд эерэг нөлөөг бий болгосон.



Иргэн айл өрхийн нийгмийн идэвх оролцоог

үнэлж, дүгнэх журмыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Иргэн айл, өрхийн нийгмийн идэвх оролцоог үнэлж, дүгнэх журмыг нэгдүгээр хавсралтаар
2. Иргэдийн оролцоог дүгнэх самбарын загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Журмыг иргэдэд танилцуулж, хэрэгжүүлэн ажиллахыг багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга, Багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
4. Журмын хэрэгжилтийн тайлан, нэгтгэлийг иргэдийн Төлөөлөгчдийн хуралд

Хавсралт 1. Иргэн айл өрхийн нийгмийн идэвх оролцоог үнэлж, дүгнэх журмыг батлах 12 дугаар тогтоол

Хавсралт 2. Иргэн айл өрхийн нийгмийн идэвх оролцоог үнэлж, дүгнэх журам

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны
2 дугаар сарын 18-ны өдрийн 19 тоот тогтоолын 1 дүгээр хавсралт

'Иргэн, айл өрхийн нийгмийн идэвх оролцоог
үнэлж дүгнэх журам'

Нэг. ЗОРИЛГО

Иргэдийг аливаа нийгэм, олон нийтийн ажилд оролцсон оролцоо, иргэний үүргээ хэрхэн гүйцэтгэж байгаагаар нь харьцуулж үнэлж, дүгнэж оролцоог нь дэмжиж, урамшуулж цаашид иргэдийг хариуцлагажуулж, хандлагыг өөрчилж, оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

Хоёр. ХАМРАХ ХҮРЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

- 2.1. Тухайн сум багт оршин суугаа 18-70 насны иргэдэд хамрагдана.
- 2.2. Гадна яваа болон хүндэтгэх шалтгаантай, хаяг дээрээ тодорхойгүй хугацаагаар байхгүй байгаа өрхөд хамаарахгүй.
- 2.3. Баг бүрт өрхийн тэргүүлэгчдийн нэртэй оролцооны самбар байршуулна.
- 2.4. Журмын дагуу оролцооны самбарт иргэдийн нийгмийн идэвх оролцоог дүгнэх шалгуур үзүүлэлттэй байна.
- 2.5. Өрхийн гишүүдийн оролцооны үзүүлэлтийг өрхийн тэргүүлэгчдийн үзүүлэлтэд нэмж тооцно.
- 2.6. Баг бүрт иргэдийн оролцоог дүгнэх комисс байгуулагдана.
- 2.7. Комисс нь тухай жилийн иргэдийг оролцуулах олон нийтийн ажил, шалгуур үзүүлэлтүүдийг баталж самбарт байршуулна.
- 2.8. Шалгуур үзүүлэлт бүрийг /0-10/ оноо болон бусад тэмдэглэлээр үнэлнэ.
- 2.9. Аливаа арга хэмжээнд 1 өрхөөс 2 ба түүнээс дээш төлөөлөл оролцсон тохиолдолд бүтэн оноо авна.
- 2.10. Багтаа олон нийтийн эрх ашигт нийцсэн санал санаачилга гаргаж, хэрэгжүүлсэн тохиолдолд тухай өрх нийт онооны 20 хувийн нэмэгдэл оноо авна.
- 2.11. Комиссын бүрэлдэхүүнд БИНХ-ын дарга, БЗД болон багийн албадууд иргэний төлөөлөл багтана.
- 2.12. Сумын төвийн багт онцлогт нь тохирсон шалгуур үзүүлэлт байна.

Гурав. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- 3.1. БИНХ-ын оролцсон оролцоо
- 3.2. БИНХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангасан байдал
- 3.3. Багт зохион байгуулагдаж буй олон нийтийн ажилд оролцсон байдал
- 3.4. Малчид малаа тарилга туулгад хамрагдуулсан байдал

3.5. Бусад

Дөрөв. ИТХ-ЫН ЧИГ ҮҮРЭГ

- 4.1. Журмын хэрэгжилттэй холбоотой журмын нэмэлт өөрчлөлтийг хариуцаж батлана.
- 4.2. Журмын хэрэгжилтийг хангуулж, тайланг хэлэлцэнэ.

Тав. ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДҮГНЭХ КОМИССЫН ЧИГ ҮҮРЭГ

- 5.1. Иргэдэд журмыг танилцуулна.
- 5.2. Оролцооны самбарыг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан байршуулна.
- 5.3. Самбарыг иргэдэд нээлттэй байлгана.
- 5.4. Журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу харьцуулж дүгнэнэ.
- 5.5. Шалгуур үзүүлэлт хамаарах олон нийтийг хамарсан ажлын зарыг иргэдэд чанартай хүргэх ажлыг хариуцна.
- 5.6. Оролцооны үзүүлэлтүүдийг улирал тутамд дүгнэж, жилийн эцэст нэгтгэнэ.

Зургаа. ДҮН НЭГТГЭЛ, УРАМШУУЛАЛ

- 6.1. Баг бүрээс хамгийн нийгмийн идэвх оролцоо сайн өндөр оноотой 3 өрхийг шалгаруулна.
- 6.2. Өрхийн нийгмийн идэвх оролцооны үзүүлэлт нь гавьяа шагнал, нийгмийн бүх төрлийн тусламж, дэмжлэг, төсөл хөтөлбөрт хамрагдахад нэг үзүүлэлт болно.

Долоо. ХҮЧИН ТӨГӨЛДӨР, ХҮЧИНТЭЙ ҮЙЛЧЛЭХ ХУГАЦАА

- 7.1. Энэхүү журмыг 2019 оны 3-р сарын 1-ны өдрөөс 11-р сарын 30-ны өдөр хүртэл дагаж мөрдөнө.



2. Завхан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

АРД ТҮМЭНДЭЭ ХҮРЧ АЖИЛЛАСАН “АРД ИРГЭДЭЭ СОНСЪЁ АЯН”**САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ****Ц.БАЛХЯРВАА**, Завхан аймгийн ИТХ-ын дарга.

Нягтлан бодогч, эрх зүйч, төрийн удирдлагын менежерээр мэргэжсэн. 1998 оноос төрийн албанд удирдах албыг хашиж байсан туршлагатай. Сүүлийн жилүүдийн ажлын туршлагаас дурдвал: 2009-2012 онд Завхан аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга, 2012-2016 онд Аймгийн ИТХТ-ийн нарийн бичгийн дарга, 2016 оны 07 сарын 29-ний өдрөөс эхлэн Аймгийн ИТХ-ын даргаар ажиллаж байна.

Холбоо барих утас: 88882121, Цахим хаяг: Bal_212175@yahoo.com

АГУУЛГА

“Ард иргэдээ сонсъё” аяныг жилд 3 удаа зохион байгуулж иргэдийн санал хүсэлт, орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Орон нутгийн иргэд өөрсдийн амьдарч буй орчин нөхцөлийг сайжруулах, шийдвэрлэх шаардлагатай асуудалд иргэний зүгээс үзэл бодлоо илэрхийлэх, шинэ санаачилга гаргахад өөрсдийн хувь нэмрээ оруулах боломж бүрдэхгүй байсан. Ялангуяа хөдөө орон нутагт амьдарч буй малчин иргэдийн саналыг авах, үзэл бодлыг сонсох асуудлууд тулгамдаж байсан. Мөн төрийн үйлчилгээний чанар хүртээмж, ард иргэдээр үнэлүүлж, санал хүсэлтийг авах, ард иргэддээ хүрч ажиллах асуудал тулгамдсан.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Завхан аймгийн 24 сумын айл өрхийн 70 хувийг тус аяны хүрээнд хамруулан санал хүсэлтийг авав.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2017 оны 1-р сараас 2019 оны 12-р сар хүртэлх хугацаанд хэрэгжүүлсэн.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

- “Face to face” аргачлалаар буюу өрхийн гишүүдтэй нүүр тулсан ярилцлага хийн санал хүсэлтийг авсан.
- “Аймгийн засаг дарга ард иргэдээ сонсъё аян”-аар иргэдийн санал хүсэлтийг авахдаа САТІ буюу утсаар санал, хүсэлт авах аргыг ашигласан.
- Цахим орчинд “Завхан аймгийн ИТХ” группээр дамжуулан иргэдийн санал хүсэлтийг авах ажлыг нээлттэй байдлаар өрнүүлсэн.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- “Ард иргэдээ сонсох аян”-ыг аймгийн Хурлын Тэргүүлэгчид, Ажлын албанаас аймгийн Засаг дарга, Тамгын газартай хамтран 2017 оноос хойш хийсэн бөгөөд, 2019 онд 3 удаа зохион байгуулсан. “Ард иргэдээ сонсох V аян”-аар нийт айл өрхийнхөө 70 хувь буюу 14.4 мянган өрхөөр орж төрийн үйлчилгээ үзүүлдэг аймаг, сумдын төрийн



байгууллага, төрийн албан хаагчдын ажлыг иргэдээр үнэлүүлж, санал хүсэлтийг нь авч ажлын тайлан цаг үеийн ажлын мэдээлэл хүргэж ажилласан.

- “Ард иргэдээ сонсох VI аян”-ыг 8 дугаар сард зохион байгуулж төрийн цогц үйлчилгээг хөдөөгийн 88 багийн иргэдэд хүргэж саналыг авсан.
- “Ард иргэдээ сонсох VII аян”-ыг 10 дугаар сард сумдын төвүүдийн 22 багийн иргэдийг хамруулж аймгаас хэрэгжүүлсэн ажлын тайланг тавьж, иргэдийн саналыг авсан
- “Ард иргэдээ сонсох аян” 2019 онд 3 удаа зохион байгуулагдаж 48,0 мянган иргэд хамрагдаж иргэдээс 23000 санал хүсэлт авч нэгтгэж эрэмбэлэн, шийдвэрлэх асуудлыг гаргасан. Энэхүү арга хэмжээний зохион байгуулалтад аймаг, сумдын Хурлын Төлөөлөгчдийг оролцуулж тэднийг иргэд сонгогчидтой нь уулзуулж бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлөөр хангасан.



“Ард иргэдээ сонсох” VII аяны санал авах уулзалтын үеэр



“Ард иргэдээ сонсох” VII аяны санал авах уулзалтын үеэр иргэд саналаа хуваалцаж байна.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Ард иргэдээ сонсох аяныг зохион байгуулахад шаардлагатай хөрөнгийг жил бүр орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэж аймаг, сумдын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлдэг. Тухайлбал: 2017 онд орон нутгийн төсвөөс, 2018, 2019 онд орон нутгийн хөгжлийн сангаас төсвийг шийдвэрлэж хэрэгжүүлсэн.

ХҮРСЭН ҮР ДҮН

- “Ард иргэдээ сонсох аян”-аар иргэдээс гарсан санал хүсэлтийг авч, давтагдсан ажил хэрэгч саналуудыг аймаг сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон төрийн захиргааны байгууллагуудын жилийн ажлын төлөвлөгөөнд жил бүр тусган хэрэгжүүлж ажилладаг болсон.
- Иргэд оршин сууж буй байршлаас үл хамааран төрийн үйлчилгээ болон орон нутгийн хөгжил дэвшилтэй холбоотой асуудлаар санал хүсэлтээ хүргүүлэх боломж бүрдсэн.
- Иргэд зөвхөн уламжлалт аргаар (бичгээр) санал хүсэлтээ хүргүүлэх бус орчин үеийн технологийн дэвшил, цахим орчныг ашиглан санал хүсэлтээ шуурхай хүргүүлэх боломж бүрдсэн.
- Иргэдэд мэдээ мэдээллийг түргэн шуурхай цаг алдалгүй хүргэх нь их чухал байсан тул Завхан аймгийн төрийн албан хаагч бүр 3-5 айл өрхийг хариуцаж, төр-иргэнийг холбох гүүр болон ажиллаж байна. Өөрөөр хэлбэл иргэд өөрийнхөө өмнө тулгамдаж буй төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хариуцсан төрийн албан хаагчдаараа дамжуулан мэдээлэл солилцох болсноор төрийн үйлчилгээг илүү шуурхай, чирэгдэлгүй хүргэж байна.

- Иргэдийн гаргасан санал хүсэлтэд тулгуурлан орон нутгийн бодлого тодорхойлогдож, цаашид хийх ажлын төлөвлөгөө гардаг болсон нь ард иргэдийн амьдралд ойрхон байх, асуудлыг бодитой шийдвэрлэх, нэн тэргүүний анхаарал хандуулах салбар чиглэлийг тодорхойлох боломжтой болсон.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Завхан аймаг нь хангай, говь хосолсон эрс тэс уур амьсгалтай бүсэд оршдог. “Ард иргэдээ сонсох аян”-ыг 2019 оны 1-р сард 24 сумын бүх айл өрхийн 60-аас дээш хувиар орж иргэн бүрийн саналыг авах, сум орон нутгийн удирдлагууд болон төрийн албан хаагчдын ажлыг иргэдээр үнэлүүлэх зорилт тавин ажилладаг. Энэ үед Завхан аймгийн хувьд цаг агаарын нөхцөл байдал хүнд, зарим сумдын газар нутаг цасан бүрхүүл ихтэй мөн айл өрхүүд маань таруу хол байрладаг учир бензин шатахууны болон бусад зардал өндөр гарсан. 2019 оны 8-р сард “Ард иргэдээ сонсох аян”-ыг зохион байгуулахдаа сумдаа 5 чиглэл болгон хувааж нэгэн зэрэг хөдөөгийн малчдад эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхэд ЭХО аппарат, шүдний зөөврийн ломбо гэх мэтийн зарим тоног төхөөрөмж дутагдалтай байсан.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

Манай сумын иргэдээс өмнөх жилд гаргасан саналаас нэлээд хэдэн санал бодит ажил болон хэрэгжсэн байна. Ард түмэнтэйгээ ойр ажиллаж төрийн ажлын мэдээ мэдээллээр биднийг хангаж, санал хүсэлтийг маань авч байгаад туйлын их баяртай байна. Ард иргэдээ сонсох аяныг зохион байгуулах ажилд тань амжилт хүсье.

Дөрвөлжин сумын иргэн Ш.Нармандах

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Иргэн бүрийн дуу хоолойг сонсож, төлөөллийн байгууллага болон иргэд хооронд эргэх холбоо, хамтын ажиллагааны нөхцөлийг бүрдүүлсэн.

Орон нутгийн иргэд, ялангуяа малчин иргэд төрийн үйлчилгээний чанар, хүртээмж болоод, нутгийн удирдлагын байгууллагаас гаргаж буй бодлого шийдвэр, түүний хэрэгжилтийн явцад бий болж буй нөхцөл байдлын талаар санал хүсэлтээ хэлэх, хүргүүлэх болсон.

“Ард иргэдээ сонсох аян” нь жилд 3 удаа буюу давтамжтайгаар зохион байгуулагдсан нь төрийн үйлчилгээг сайжруулах, цаашлаад орон нутагт гарч буй бодлого шийдвэрийг үр өгөөжтэй хэрэгжиж буй эсэхэд үнэлгээ хийх боломжийг олгосон.

“Ард иргэдээ сонсох аян”-ы үйл ажиллагаа нь төр-төлөөллийн байгууллага-иргэн гэсэн гуравласан гинжин хэлхээг байнгын ажиллагаатай, тасралтгүй процессоор үргэлжлэх боломжийг бий болгосон.

Аяны хүрээнд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран харилцаа холбоо үүсгэх боломжийг ашиглан цахим байдлаар иргэдийн санал хүсэлтийг авах ажлыг өрнүүлсэн нь орон нутгийн байгууллагуудад зардлаа хэмнэн, шуурхай мэдээлэл түгээх, мэдээллийг нэгтгэн авах боломжтойг харуулсан.



3. Завхан аймгийн Их Уул сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

ИРГЭДЭД ЭЭЛТЭЙ “ИРГЭН ТАНЫ ХӨТӨЧ”**САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ**

И.ЭНХТҮВШИН, Завхан аймгийн Их Уул сумын ИТХ-ын дарга. Багш мэргэжилтэй. 1996-1999 онд Завхан аймгийн Их-Уул сумын Хуягт багийн засаг дарга, 1999-2003 онд Завхан аймгийн Их-Уул сумын Хуягт багийн бага сургуулийн багш, 2004-2016 онд Завхан аймгийн Их-Уул сумын ХАА-н цаг уурч, 2016 оноос Завхан аймгийн Их-Уул сумын ИТХ-ын даргаар ажиллаж байна.

Холбоо барих утас: 89798808,

Цахим хаяг: enkhtuwshin.i1006@gmail.com

АГУУЛГА

ИТХ нь чиг үүргийнхээ хүрээнд үйл ажиллагаа болон түүнээс гарч буй тогтоол, шийдвэрийн талаарх мэдээллийг цаг тухай бүрд иргэдэд хүргэж ажиллахыг зорьдог. Энэ ажлын хүрээнд “Иргэн таны хөтөч” эмхэтгэлийн ажлын санаачлан хийж, иргэдийг мэдээллээр хангаад байна.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Орон нутгийн иргэд ИТХ-аас гарч буй шийдвэр болон үйл ажиллагааны талаар мэдээлэл маш дутмаг байдаг. Мэдээллийг хангалттай хэмжээнд, түргэн шуурхай авч чадахгүйн улмаас БИНХ-д оролцох идэвх муу, санал хүсэлтээ илэрхийлэх боломж хомс байдаг.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Завхан аймгийн Их-Уул сумын иргэд, айл өрхүүдийг хамруулсан.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2019 оны 11-р сарын 20-ны өдрөөс 2020 оны 03-р сарын 20 хүртэлх хугацаанд хэрэгжүүлсэн.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ


Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа иргэдийн нэн түрүүнд мэдвэл зохих хуулиудыг энгийн хялбарчилсан хэлбэрээр хүргэх замаар иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, иргэдэд өдөр тутмын амьдралдаа эрх зүйн мэдээ, мэдээллийг хэрэглэх чадварыг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй болгох зорилгоор Монгол улсын хууль, тогтоомжоос иргэдэд өдөр тутам хэрэглэдэг зүйл заалтуудыг түүвэрлэн эмхэтгэж, сумын ЗДТГ-ын албан хаагчид, Төсөвт байгууллагуудын дарга эрхлэгч, аймгийн мэргэжилтнүүдийн холбогдох утасны дугаар, сумын бүх өрхүүдийн утасны дугаарыг баг тус бүрээр нэгтгэн иргэдийн хэрэгцээнд зориулсан “Иргэн таны хөтөч” эмхэтгэлийн эхийг бэлтгэж 1050 ширхгийг хэвлүүлэн иргэдэд хүргэн ажиллаж байна.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа иргэдэд нэн түрээнд хэрэглэгдэх хууль, тогтоомжуудыг судалсан.



- Хууль тогтоомжуудаас иргэний эрх, үүрэгтэй холбоотой заалтуудыг түүвэрлэн авсан.
- Орон нутгийн холбогдох төрийн албан хаагч, улсын байцаагчдаас иргэдэд хүргэх, дүрэм, журмыг нэгтгэн авсан.
- Багийн Засаг дарга нараас багийн өрхүүдийн утасны жагсаалтыг гаргуулж, нэгтгэсэн.
- Эмхэтгэлд оруулах мэдээллийг цуглуулснаар “Иргэн таны хөтөч” эмхэтгэлийн эх бэлтгэлийг бэлдсэн.
- Эх бэлтгэлийг бэлдсэнээр “Иргэн таны хөтөч” эмхэтгэлийг 1050 ширхгийг хэвлүүлэн иргэн, айл өрхүүдэд тараасан.



Завхан аймгийн Их-Уул сумын ИТХ-аас санаачлан гаргасан “Иргэн таны хөтөч” эмхэтгэл

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Нийт төсөвт 2 сая төгрөг зарцуулсан бөгөөд “Иргэн таны хөтөч” эмхэтгэлийн 650 ширхгийг хэвлэх санхүүжилтийг “Иргэдийн оролцоо-2” төсөлд хүсэлт хүргүүлэн шийдвэрлүүлж, хамтран ажилласан. Үлдсэн 400 ширхгийг ИТХ өөрсдийн нөөц боломжийг ашиглан хэвлэсэн.

ХҮРСЭН ҮР ДҮН

- Орон нутгийн иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилж, өдөр тутмын амьдралдаа шаардлагатай мэдээллийг шуурхай авч чадсан.
- Иргэд мэдээллийг түргэн шуурхай авч чадсанаар ИТХ-аас гаргасан шийдвэрийн дагуу хэрэгжиж буй ажилд өөрсдийн дуу хоолойгоо хүргэх боломжтой болсон.
- Орон нутгийн төрийн үйлчилгээ хүргэж буй мэргэжилтнүүд болон иргэдийн харилцаа холбоо, хамтын ажиллагаа сайжирсан.
- Төрийн байгууллагын үйлчилгээ болон үйлчилгээтэй холбоотой мэдээллийг хэнээс, хаанаас, ямар шат дарааллаар мэдэж авах нь илүү тодорхой болсон.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

“Иргэн таны хөтөч” эмхэтгэл нь хууль эрх зүй, төрийн үйлчилгээ, холбоо барих мэдээлэл гэх зэрэг мэдээллийн өргөн цар хүрээг хамарсан тул хэвлүүлэхэд санхүүгийн бэрхшээл тулгарсан.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

Энэхүү хөтөч нь ард иргэдийн нэн тэргүүнд мэдэх ёстой хууль болон мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр бичсэн нь их таалагдсан. Бусад сум орон нутагт хэрэгжүүлж болохуйц сайн эмхэтгэл болсон.

Завхан аймгийн Их-Уул сумын иргэн Г. Бавуусүрэн

Энэхүү ном нь ард иргэдэд маш хэрэгтэй зүйл болсон. Учир нь малчин бидний амьдралд хэрэгтэй наад захын хууль, зөрчлийн хууль, газрын хууль гэх мэт заалт зүйлүүд орсон байна.

Завхан аймгийн Их-Уул сумын иргэн Г. Батбаяр

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

“Иргэн таны хөтөч” гарын авлагад оруулсан мэдээлэл нь энгийн, ойлгомжтой хийгдсэн нь иргэдийг мэдээллээр хангах нөхцөлийг бүрдүүлж чадсан.

Сумын иргэд “Иргэн таны хөтөч” гарын авлага бүхий эмхэтгэлээс хэрэгжиж буй хууль, журмын талаар мэдээлэлтэй болсноор төрөөс үйлчилгээ авахад хялбар болсон.

Тус эмхэтгэлд сумын төрийн албан хаагчид болон өрхийн холбоо барих утасны дугаарыг оруулсан нь холбоо харилцаатай байх, аливаа ажилд зохион байгуулалтад ороход хүндрэлгүй болсон.

4. Баянхонгор аймгийн Жаргалан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

“СУМЫН ХӨГЖИЛД-ИРГЭДИЙН ОРОЛЦОО”**САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ**

Ж.УРАНЧИМЭГ, Баянхонгор аймгийн Жаргалан сумын ИТХ-ын дарга. Барилгын технологич, нягтлан бодогч мэргэжилтэй. Жаргалан сумын ИТХ-ын даргаар 2 удаа сонгогдон ажиллаж байна.
Холбоо барих утас: 91114408,
Цахим хаяг: urnaabh@gmail.com

АГУУЛГА

Орон нутгийн ажилд иргэдийн оролцоог сайжруулах, иргэдийг идэвхжүүлэх, иргэд-удирдлагуудын уялдаа холбоог сайжруулах, иргэдийн нийгэмд хандах хандлагыг өөрчлөх зорилгоор иргэдийг байгууллагуудад хуваан хариуцсан гудамж хороололд **“идэвхтэн иргэн”** ажиллуулав.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Төрийн байгууллагуудаас хийж хэрэгжүүлж буй ажлын мэдээллийн хүртээмж хангалтгүй, тул иргэд, олон нийт төрийн байгууллагын үйл ажиллагаанд оролцох оролцоо муу, өөрсдийн санал хүсэлтээ илэрхийлэх байдал дутмаг байсан.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Баянхонгор аймгийн Жаргалан сумын иргэд.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2017 оны 03 дугаар сарын 01-ээс эхлэн жил бүр тогтмол зохион байгуулж байна.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

“Сумын хөгжилд-Иргэдийн оролцоо” нөлөөллийн ажлын удирдамж гарган гудамж, хорооллыг албан байгууллагуудад хуваарилан өгч, тухайн байгууллагууд нь хариуцсан гудамж, хороололдоо идэвхтэн ажиллуулж эхэлсэн. Энэхүү нөлөөллийн ажилд орон нутгийн иргэдийг идэвхтэй татан оролцуулахын тулд гудамж, хороолол хариуцсан **“идэвхтэн харилцах дэвтэр”**-ийг ашигласан.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- “Сумын хөгжилд-Иргэдийн оролцоо” нөлөөллийн ажлын удирдамж гарган гудамж, хорооллыг албан байгууллагуудад хуваарилан өгч, тухайн байгууллагууд нь хариуцсан гудамж, хороололдоо идэвхтэн ажиллуулж эхэлсэн. Энэ нь Монгол Улсын хууль тогтоомж, аймаг, сумын тогтоол шийдвэр сурталчлах, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, төр иргэний хамтын ажиллагааг сайжруулах, иргэдийн нийгэмд хандах хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн болно.
- Байгууллагууд гудамж, хороолол хариуцсан идэвхтнийхээ үйл ажиллагааг дүгнэж, сар бүр урамшуулна. Байгууллагууд гудамж, хороолол хариуцсан идэвхтнүүдийн үйл ажиллагааны тайланг нэгтгэн жил бүрийн эцэст файлаар болон цаасан хэлбэрээр сумын ИТХ-ын ажлын албанд ирүүлнэ. Тайланг ИТХ-аас томилогдсон ажлын хэсэг



дүгнэж, “Шилдэг байгууллага”-аар нэг байгууллагыг шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасан.

- Сум орон нутаг болон өөрсдийн дунд тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Сумын хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо”, эмэгтэйчүүдийн чуулган, Сумын хөгжилд эрчүүдийн оролцоо”, эрчүүдийн чуулган “Сумын хөгжилд-Ахмадуудын оролцоо” ахмадын чуулган, “Сумын хөгжилд-Хүүхдүүдийн оролцоо”, хүүхдийн чуулган, “Гэр бүлийн үнэ цэнэ” залуу гэр бүлийн чуулганыг 2017 оноос хойш жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Төсвийн байгууллагууд өөрсдийн хариуцаж авсан гудамж, хорооллын идэвхтнийг урамшуулах асуудлыг дотооддоо шийдсэн.

ХҮРСЭН ҮР ДҮН

- Монгол Улсын хууль, тогтоомж, аймаг, сумын хурлын тогтоол болон цаг үеийн мэдээллийг иргэдэд тухай бүр хүргэх боломж бүрдсэнээр мэдээллийн чанар, хүртээмж сайжирч, иргэдийн оролцоо нэмэгдсэн.
- Төр иргэний хамтын ажиллагаа сайжирч, иргэдийн нийгэмд хандах хандлага өөрчлөгдсөн.
- ИТХ нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөвшилт, иргэдийн чадавхыг сайжруулахын тулд иргэдийн төлөөлөл гаргах шийдвэрээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Иргэдийг идэвхжүүлэх зорилгоор уралдаан тэмцээн, тэмдэглэлт үйл ажиллагаа, баяр наадам, сургалт зэргийг тогтмол зохион байгуулж байна. Энэхүү ажлын хүрээнд өмнө нь идэвх оролцоогүй байсан иргэд орон нутгийн төрийн байгууллагын ажилд идэвхтэй оролцохоос гадна, үйл ажиллагааг дэмжин оролцдог болсон. Өмнө нь орон нутгийн зохион байгуулсан бүх арга хэмжээнд төсвийн ажилтан оролцдог байсан бол одоо иргэд олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явагддаг болж иргэд илүү мэдлэг авахаас гадна үүрэг оролцоо нэмэгдэж, хоорондоо өрсөлдөх маягаар сонирхолтой арга хэмжээнд оролцдог болсон. Иргэд өөрсдөө санаачилга гаргадаг, байгууллагын идэвхтэн гишүүд өөрсдөө үйл ажиллагааг зохион байгуулдаг болсон.
- Иргэдийн идэвх, оролцоо нэмэгдэж, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах боломж бий болсон байна.
- Төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоо сайжирч, төр, иргэний хамтын ажиллагаа бэхэжнэ.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Гудамж, хороолол хариуцсан идэвхтэний урамшууллыг тухайн байгууллагууд өөрсдөө хариуцаж байгаа учраас санхүүгийн хувьд хүндрэл учирсан. Үйл ажиллагааг хийж эхлэх явцад иргэдийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо хангалтгүй байсан.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

Сумын төвд Идэвхтэн гишүүн ажилласнаар төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг цаг алдалгүй авах, иргэд олон нийтийг мэдээллээр хангах зэрэг давуу талууд үүсдэг. Өмнө нь мэдээллээ айл бүрээр явж тараадаг байсан бол одоо иргэдийг групп мессеж үйлчилгээнд холбож идэвх оролцоог сайжруулсан. Идэвхгүй байсан иргэд идэвхжиж бие биеэ уриалан үлгэр жишээ болж суман дах бүтээн байгуулалттай шууд хамааралтай болж байгаа юм.

Жаргалан сумын иргэн С.Батцэцэг




СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Сум орон нутагт батлагдан хэрэгжиж буй бодлого, шийдвэрт санал бодлоо тусгаж, шийдвэр гаргах түвшинд иргэдийн дуу хоолой чухал хэрэгцээ шаардлагатай талаар иргэд ойлголттой болсон.

Иргэдийг урамшуулах үе шаттайгаар үйл ажиллагааг зохион байгуулсан нь төлөөллийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог татан оролцуулах, нөлөөллийн ажлыг үр дүнтэй байлгахад чухал нөлөө үзүүлсэн.

Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлж ажиллахад баг, сумын төлөөллүүд мөн аж ахуй нэгж байгууллагын оролцоотойгоор хамтран ажилласан нь цаашдын үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлсэн.

Хавсралт 1. Сумын хөгжилд-Иргэдийн оролцоо нөлөөллийн ажлын удирдамж

**“СУМЫН ХӨГЖИЛД-ИРГЭДИЙН ОРОЛЦОО”
НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН УДИРДАМЖ**

2017 оны 02 дугаар сарын 19

ЖКаргалант

Нэг. Зорилго: Төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн уялдаа холбоог нэмэгдүүлэх, иргэдийн идэвхийг өрнүүлэх, төр, иргэний хамтын ажиллагааг сайжруулах, иргэдэд хууль эрх зүйн мэдлэг олгох, иргэдийн нийгэмд хандах хандлагыг өөрчлөх зорилгоор гудамж, хороолол хариуцсан идэвхтэн ажиллуулахад оршино.

Хоёр. Хугацаа: 2017 оны 03 дугаар сарын 01-ээс жил бүр тогтмол зохион байгуулах

Хамрах хүрээ: Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Байдраг ахлах сургууль, Сум дундын эмнэлэг, Цэцэрлэг, Соёлын төв

Дөрөв. Үйл ажиллагааны чиглэл:

-Сумын Засаг даргын Тамгын газраас гудамж, хорооллыг төрийн байгууллагуудад хуваарилан өгч, хариуцуулах

-Байгууллага бүр хариуцсан гудамж, хороололдоо 1-2 идэвхтэн ажиллуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах

Тав. Гудамж, хороолол хариуцсан идэвхтнүүдийн хийх ажлын чиглэл:

-Хариуцсан гудамж, хорооллын айл өрхүүдийн нарийвчилсан судалгаа гаргах

-Хариуцсан гудамж, хорооллын иргэдийн дунд мессеж групп нээж, мэдээлэл хүргэх

-Монгол Улсын хууль, тогтоомж, аймаг, сумын тогтоол шийдвэрийг иргэдэд сурталчлах, мэдээлэх

-Хариуцсан гудамж, хороололд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах талд санаачилгатай ажиллах

-Төрийн болон бус байгууллагуудаас зохион байгуулсан сургалт, хурал, уулзалтад иргэдийг оролцуулж, ирцийн бүртгэл бүртгэл хөтлөх

-Идэвхтэн өөрөө санаачлан ажил зохион байгуулах

-Хариуцсан гудамж, хорооллын иргэдийн санал, хүсэлтийг холбогдох албан тушаалтанд уламжилж, шийдвэрлүүлэх

-Сар бүр хийсэн ажлаа тайлагнаж, дүгнүүлэх

Зургаа. Дүгнэх, урамшуулах:

-Байгууллагууд гудамж, хороолол хариуцсан идэвхтнийхээ үйл ажиллагааг дүгнэж, сар бүр урамшуулна.

-Байгууллагууд гудамж, хороолол хариуцсан идэвхтнүүдийн үйл ажиллагааны тайланг нэгтгэн жил бүрийн эцэст файлаар болон цаасан хэлбэрээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд ирүүлнэ.

-Тайланг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилогдсон ажлын хэсэг дүгнэж, "Шилдэг байгууллага"-аар нэг байгууллагыг шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

Долоо. Хүрэх үр дүн:

-Монгол Улсын хууль, тогтоомж, аймаг, сумын хурлын тогтоол болон цаг үеийн мэдээллийг иргэдэд тухай бүр хүргэх боломж бүрдсэн байна.

-Иргэдийн идэвх, оролцоо нэмэгдэж, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах боломж бий болсон байна.

- Төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоо сайжирч, төр, иргэний хамтын ажиллагаа бэхэжнэ.



5. Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

“АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАГЧ ХАМГААЛАГЧИД”**САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ**

Ш.ГАНЧИМЭГ, Улаанбаатар хотын БЗД-ийн ИТХ-ын дарга. Эдийн засагч мэргэжилтэй. Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын “Хөгжил нэгдэл”-д эдийн засагч, 2001-2017 онд БЗД-ийн Ардчилсан намд Хэрэг эрхлэг газрын дарга, 2013-2016 онд БЗД-ийн 7 дугаар хорооны төлөөлөгч, 2016 оноос хойш БЗД-ийн ИТХ-ын даргаар ажиллаж байна.

Холбоо барих утас: 89798808,

Цахим хаяг: enkhtuwshin.i1006@gmail.com

АГУУЛГА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор хэрэгжиж буй “Хүүхэд хамгаалагч” төслийг дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх зорилгоор “Хүүхэд хамгаалагч”-дыг ажиллуулж байна. Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд “Гэрээс сургууль, сургуулиас гэр” хүртэлх аюулгүй орчныг бий болгох зорилготой.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Дүүргийн бүс нутагт гэмт хадлагад өртөх үзэгдэл сүүлийн жилүүдэд ихэссэн. Ялангуяа ЕБС-ийн сурагчид гэр хорооллын гудамж талбай, олон газар гэмт халдлагад өртөх асуудал ихсэж, хүүхдэд ээлтэй, аюулгүй бүсийг бий болгох шаардлагатай болсон.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

БЗД-ийн хэмжээнд ЕБС-ийн 1-12 дугаар ангийн сурагчид.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2017 оноос 2020 он хүртэл тус төслийг хэрэгжүүлсэн.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

Олон нийтийн оролцоо, хамгаалал аргачлалыг ашигласан. Тухайлбал хүүхдийн сургууль, гэр хоорондох зам, гудамж талбайн аюулгүй байдлыг тухайн хорооны иргэдээс бүрдсэн “Хүүхэд хамгаалагч” багийнхан хичээлд ирэх, тарах цагаар эргүүлийн үүрэг гүйцэтгэнэ. Энэ нь хүүхдийн эсрэг үйлдэх гэмт хэрэг болох танхай, дээрэм, хулгай гэх мэт халдлагаас урьдчилан сэргийлнэ.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- 2018 онд Баянзүрх дүүргийн 2, 4, 21, 27 дугаар хороодод туршилтын цэгийг байгуулан ажиллаж цаашид бусад хороодод нэвтрүүлж эхэлсэн. Нийт 28 цагт явган эргүүл ажиллаж, тухайн бүсийг камержуулсан. Мөн тус дүүргийн 86 иргэн сайн дураар явган эргүүлд гарч ажилласан.
- 2018 онд Баянзүрх дүүргийн 5 дугаар хорооны эрсдэлт цэгүүдэд иргэдийг эргүүлд гаргах “Хүүхэд хамгаалагч” пайз, сандал суурилуулан төслийг иргэдэд танилцуулах арга хэмжээг тус дүүргийн нутаг дэвсгэр дэх ЕБС-ийг түшиглэн зохион байгуулсан.
- Судалгаанд суурилсан 150 эрсдэлт цэгт ажиллах хүүхэд хамгаалагчдыг Хүчний байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан алба хаагчдыг сонгож, “Хүүхэд



хамгаалагч” самбар, сандал байршуулан, ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор шаардлагатай тусгай хэрэгслийг орон нутгийн хөрөнгөөр шийдвэрлэсэн.

- 2019 онд дүүргийн 28 хороодод байрлал их, дээд, ерөнхий боловсролын сургуулийн захирал, нийгмийн ажилтнууд, хороодын засаг дарга, нийгмийн ажилтнууд, хэсгийн байцаагч нарын дунд “Хүүхэд хамгаалагч” төслийг танилцуулах сургалт, өдөрлөгийг 2019.09.17-18-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 150 орчим албаны хүмүүсийг хамран 2019-2020 оны хичээлийн жилд хамтран ажиллах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 6 их сургууль, 25 ерөнхий боловсролын сургууль, 3 цэцэрлэгтэй гэрээ байгууллаа.
- Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийг “Гэрээс сургууль, сургуулиас гэр” хүртэлх аюулгүй орчныг бий болгох зорилгоор цагдаагийн байгууллагатай хамтран гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй 190 цэгийн судалгааг гаргаж, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид өөрсдийн хариуцсан хороод дээр хяналт тавин, дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Мөн хүүхэд хамгаалагчийн хэрэглэх хэрэгслэгдэхүүн /шүгэл, дэвтэр, гар чийдэн/ самбар, сандал зэргийг ИТХ-ын төсвөөс санхүүжүүлэн ажиллаж байна.



Баянзүрх төвийн “Хүүхэд хамгаалагч” төслийн сайн дурын багийнхан



Баянзүрх төвийн “Хүүхэд хамгаалагч” төслийн багийнхан

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

ИТХ-ын санхүүжилтээр шийдэж дараах захирамжуудыг гаргасан.

- БЗД-ийн ИТХ-ын Даргын захирамж 2019 оны 06 сарын 24 өдөр дугаар А/40 “Хүүхэд хамгаалагч туршилтын төслийг хэрэгжүүлэхэд хөрөнгө гаргах тухай”
- Баянзүрх дүүргийн ИТХ-ын Даргын захирамж 2019 оны 012 сарын 20 өдөр дугаар А/91 “Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газрын 3 дугаар хэлтэст хүүхэд хамгаалагч туршилтын төслийг хэрэгжүүлэхэд хөрөнгө гаргах тухай”

ХҮРСЭН ҮР ДҮН

- Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт сурагчдын аюулгүй байдлыг сургуулийн орчинд “Эцэг эхийн эрүүл”, гудамж талбай, гэрэлтүүлэггүй, камерын хяналтгүй эрсдэлт газруудад “Хүүхэд хамгаалагч”-ийг ажиллуулснаар Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсан “Хүүхэд эрүүл, аюулгүй орчинд” амьдрах эрх нь хангагдаж сургуулийн ойр орчимд гарах гэмт хэрэг зөрчлийн тоо буурч, хүүхэд хамгаалах үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо нэмэгдсэн.

- 2018 онд бүрдгээгдсэн нийт гэмт хэрэг 2019 онд 23.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
- Үйл ажиллагааг амжилттай болгох, олон нийтэд сурталчлан таниулахад спортын тамирчидтай хамтран ажилласан.
- Хүүхэд хамгааллын ажилд зөвхөн төрийн алба хаагчид хүчин зүтгэх бус иргэд, олон нийтээрээ хамтран ажиллах нь илүү үр дүнтэй ажил болж буйг харуулсан байна.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Энэхүү төсөл нь суурь судалгаа болон урт хугацааны туршид хийгдсэн бусад төслүүдэд үндэслэн хийгдсэн тул бэрхшээл тулгараагүй.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЛЭЭС

Хүүхэд хамгаалагч төслийн хүрээнд 6-8 саруудад БЗД 4 хорооны нутаг дэвсгэрт гарч ажиллаа. 7-8 сард харах хүнгүй хүүхдүүд гадуур дэмий сэлгүүцэх, халуунд гадаа тоглож нарших зэрэг эрсдэлүүд байсан. Ингэж хүүхэд хамгаалагч ажилласнаар эрсдэлийг бууруулж чадсан. Цаашид ч мөн эцэг эхчүүд хамран ажиллаж илүү үр дүнд хүрэх байх гэсэн итгэлтэй байна.

БЗД-ийн 4 хорооны иргэн Г.Түвшинжаргал

Хүүхэд бол бидний ирээдүй. Хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах бол томчууд бидний үүрэг. Би олон жишээ сонсож байсан хүүхэд хэн нэгэнд дээрэлхүүлэх, нохойнд дайруулах гээд олон асуудал байдаг. Хүүхэд хамгаалагч аяныг хэрэгжүүлснээр хүүхдүүдийн сургууль цэцэрлэгтээ ирж очих зам айх аюулгүй тайван байдаг.

Мэргэжлийн боксын дэлхийн аварга Ч. Цэвээнпүрэв.

ДҮҮРГИЙН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Дүүргийн бүс нутагт гарах гэмт хэргийн тоо буурч, гэрээс сургууль-сургуулиас гэр хүрэх замд сурагчид аюулгүй зорчих нөхцөл бүрдсэн.

Эцэг эх, асран хамгаалагчид, багш, сурагчид, иргэд төрийн албан хаагчидтай хамтран нийгмийн сайн сайхан байдлын төлөө ажиллах шаардлагатай гэдгийг ойлгосон.

Төрийн байгууллагууд, төрийн алба хаагчид иргэдийн тусламж хамтын ажиллагааны үр дүнд дүүргийн нутаг дэвсгэрт тулгамдаж буй асуудлыг үе шаттайгаар шийдэх боломжтойг харуулсан.

Хичээлийн бус цагаар гадуур явж буй хараа хяналтгүй хүүхдүүдэд гэнэтийн аюул, осол тохиолдохоос урьдчилан сэргийлсэн.

Хавсралт 1. Хүүхэд хамгаалагч төслийг иргэдэд сурталчлах нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах А/26 дугаар захирамж**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

Хүүхэд хамгаалагч төслийг иргэдэд
сурталчлах нээлттэй хаалганы өдөрлөг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дах заалт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дах заалт, 16 дугаар зүйлийн 16.3.3 дах заалт, 19 дүгээр зүйлийн 19.3.1 дах хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дах хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.5 дах заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2019 оны А/23 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор хэрэгжүүлж буй "Хүүхэд хамгаалагч" төсөл, "Зөв тусгал" хөдөлгөөнийг иргэдэд сурталчлах нээлттэй хаалганы өдөрлөгийг 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсугай.

2. Нээлттэй хаалганы өдөрлөгийн удирдамжийг нэгдүгээр, гэмт хэрээс урьдчилан сэргийлэх сурталчилгааны материал хэвлүүлэх зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Өдөрлөг зохион байгуулах, сурталчилгааны материал хэвлүүлэхэд шаардагдах нийт 5,430,600 /таван сая дөрвөн зуун гучин мянга зургаан зуу/ төгрөгийг холбогдох зардлаас, зохих журмын дагуу гаргахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Г.Болормаа/, нягтлан бодогч /М.Шинэцэцэг/ нарт зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт гавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Г.Болормаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ГАНЧИМЭГ

E:\2019 онii баримт бичиг\zahiramj 2019.docx

1130100053

Хавсралт 2. Хүүхэд хамгаалагч туршилтын төслийг хэрэгжүүлэхэд хөрөнгө гаргах тухай А/40 дугаар захирамж**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

Хүүхэд хамгаалагч туршилтын төслийг
хэрэгжүүлэхэд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дах заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дах хэсэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.3 дах хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.3.5 дах хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.5 дах заалт, Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/116 дугаар тушаалын 7 дугаар зүйл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2019 оны А/15 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Цагдаагийн Ерөнхий газраас хэрэгжүүлж буй "Хүүхэд хамгаалагч" туршилтын төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг шийдвэрлэсүгэй.

2. Хүүхэд хамгаалагч төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн задаргааг хавсралтаар баталсугай.

3. Хөрөнгө худалдан авахад шаардагдах 6,780,000 /зургаан сая долоон зуун наян мянга/ төгрөгийг холбогдох зардлаас, зохих журмын дагуу гаргахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Г.Болормаа/, нягтлан бодогч /М.Шинэцэцэг/ нарт зөвшөөрсүгэй.

4. Хүүхэд хамгаалагч төслийн хэрэгжилтийг улирал бүр ирүүлж байхыг дүүрэг дэх Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн дарга /Т.Дамбийням/-д үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Г.Болормаа/-д даалгасугай.

ДАРГА



Ш.ГАНЧИМЭГ

E:\2019 оны баримт бичиг\zahiramj 2019.docx

1130100093

6. Увс аймгийн Ховд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

“ЦАХИМ ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛ”

САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ



П.ДАВААНЫМ, Увс аймгийн Ховд сумын ИТХ-ын дарга.

Эдийн засагч мэргэжилтэй. 2005-2016 онуудад Увс аймгийн Ховд сумын Хаан банканд эдийн засагч, 2008-2012 онуудад ИТХ-ын төлөөлөгчөөр ажиллаж байна.

Холбоо барих утас: 90331616

Цахим хаяг: davaanyam.poonio@gmail.com

АГУУЛГА

БИНХ-д залуучуудын санал бодлыг нээлттэйгээр тусгах зорилгоор, сумын иргэдийн онцлог, өнөөгийн нөхцөл байдлаас шалтгаалан цахим орчинд иргэдийн хурлын хийсэн.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

БИНХ-ын ирц хангалтгүй байдаг. Айл өрхүүд багийн төвөөс алслагдсан хол байрлалтай байдгаас шийдвэрт тэр бүр оролцож чадахгүй байсан. Сум орон нутгийн онцлогоос үүдээд малчин иргэд ИТХ-аас гаргаж буй ажил үйлчилгээнд санал хүсэлтээ илэрхийлэх, ИНХ-ын танхимын хэлэлцүүлэгт оролцох боломж хязгаарлагдмал байдаг. Мөн цаг үеийн мэдээлэл, ИТХ-аас гаргаж буй шийдвэр тогтоол, аливаа үйл ажиллагааны тухай мэдээллийг айл бүрд хүргэхэд хүн хүчний болон хөрөнгө санхүүгийн асуудал тулгамдаж байсан.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Увс аймгийн Ховд сумын иргэдийг хамруулав.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2018 оны 5 сараас эхлэн 2020 оны 03 дугаар сар хүртэл тасралтгүй хэрэгжүүлж байна.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ


Мэдээлэл харилцааны технологийг ашиглан иргэдийн санал хүсэлтийг сонсох аргыг ашигласан. Сумын иргэд санал бодлоо солилцох, ИТХ-аас гарсан тогтоол шийдвэр, хийсэн ажлаа танилцуулах, санамж зөвлөмж, урьдчилан сэргийлэх мэдээлэл өгөх зорилгоор сумын ИТХ-аас санаачлан фейсбүүк групп ажиллуулсан. Тус групп нь одоогоор 6000 гаруй гишүүнтэй болсон байна.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- Ховд сумын ИТХ-ын төлөвлөгөөг баталсан,
- Ховд сумын ИТХ-ын Фейсбүүк групп үүсгэсэн,
- Ховд сумын ИТХ-ын Фейсбүүк группийг иргэдэд сурталчлан таниулах ажлыг хийсэн,
- Иргэдийн дунд хэлэлцүүлэх хэлэлцүүлгийн сэдэв тодорхойлох, санал асуулга явуулах, цаг үеийн мэдээ мэдээлэл оруулах ажлыг үе шаттайгаар хийсэн,



- ИТХ-ын төлөөлөгчид Иргэдээс гарсан санал санаачилгыг эрэмбэлэн, нэгтгэн дүгнэсэн,
- Иргэдээс гарсан санал санаачилгыг цаашидын ажлын төлөвлөгөөнд тусгах, асуудлыг



Увс аймгийн Ховд сумын ИТХ-ын цахим хэлэлцүүлэх өрнүүлдэг групп нэн даруй шийдвэрлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Тус ажлыг зохион байгуулахад төсөв, санхүү шаардлага гараагүй.

ХҮРСЭН ҮР ДҮН

- Иргэд мэдээллийг цаг алдалгүй хүлээн авч санал бодлоо илэрхийлж, БИНХ-д оролцох, мэдээлэл авах, санал хүсэлтээ илэрхийлэх, төрийн үйлчилгээний анхан шатны мэдээлэл авах зэрэгт сумын төв рүү ирэх шаардлагагүй болсон.
- ИТХ-аас гаргаж буй шийдвэр тогтоол, цаг үеийн мэдээ мэдээллийг айл өрх бүрд очиж хүргэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх, хэвлэмэл материал бэлтгэх зэрэгт санхүүгийн болон цаг хугацааны хэмнэлт хийх боломжтой болсон. Цаашид энэ аргачлалыг хөгжүүлэн иргэд аймгийн үйл ажиллагаанд ч мөн хяналт тавих санал хүсэлтээ илэрхийлэх боломжтойг харуулсан.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Иргэд группийн зорилгыг өөрөөр ашиглах, мөн орон нутгийн онцлогоос шалтгаалж сүлжээ, интернэт хурд муу байх зэрэг асуудлууд тулгардаг.

Олон нийтийн сүлжээний хүрээнд явагддаг тул мэдлэг боловсрол, нийгмийн янз бүрийн давхаргын хүн шууд оролцдоогоос үүдэн үндсэн сэдвээс гажих асуудал тохиолдож байсан.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

Сум орон нутагтай холбоотой мэдээ мэдээллийг Увс аймгийн Ховд, Ховд сумын зарын нэгдсэн групп, Ховд сумын ЗДТГ-ын цахим хуудаснаас авч байна. Ерөнхий мэдээллийг эдгээр хуудсаар дамжуулан авч шаардлагатай тохиолдолд коммент үлдээж холбогдох ажилтнуудаас нэмэлт мэдээлэл авч байна. Хурдан шуурхай, цаг алдалгүй хүн бүрд мэдээлэл очиж, олныг хамруулах иргэд ч сум орон нутгийнхаа талаарх саналаа хэлж оролцох боломжийг бүрдүүлж байна.

Ховд сумын иргэн Г. Амарзаяа



СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Сумын иргэд ялангуяа малчид амьдарч буй газраас үл хамааран төлөөллийн байгууллагын үйл ажиллагаанд санал хүсэлтэй илэрхийлдэг болсон.

Сумын иргэдийн хувьд сумын төвд байнгын оршин суудаг ахмадууд ихэвчлэн БИНХ-д оролцдог байсан бол цахим хурлыг хийснээр бүх насныхан ажил, мэргэжлээс үл хамааран оролцох болсон.

Цахимаар иргэдээс санал хүсэлт авах нь хурлыг биечлэн зохион байгуулахаас илүү, цаг хугацаа хэмнэх болсон.

Цахим хуралд бүх насны төлөөлөл хамрагдан санал хүсэлтээ өгснөөр орон нутагт хийгдэж буй бодлого, шийдвэр болон хийгдэхээр санаачилж буй цаашдын ажлуудад өгөх санал нь бодитой, бүх насныхны хэрэгцээ шаардлагыг илэрхийлэх болсон.

Орон нутагт мэдээллийг хүргэх арга барилд өөрчлөлт гарсан.

7. Хэнтий аймгийн Галшар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

“ТӨЛӨӨЛӨГЧИЙН ӨДӨРЛӨГӨӨР”**САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ**

П.ЭНХБААТАР, Хэнтий аймгийн Галшар сумын ИТХ-ын дарга.
ХААИС-ыг малын эмч мэргэжлээр төгссөн. Галшар сумын Засаг даргаар 16 жил, ИТХ-ын даргаар 4 жил ажиллаж байна.
Холбоо барих утас: 99185768, 88139590
Цахим хаяг: amuu0318@gmail.com

АГУУЛГА

Төлөөлөгчдийн өдөрлөгийн хүрээнд иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулсан.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Орон нутгийн иргэд мэдээлэл дутмаг, олон нийтийн үйл ажиллагаанд хамрагдалт хангалтгүй байв.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Хэнтий аймгийн Галшар сумын иргэд.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

Жил бүрийн 7 дугаар сарын 25-ны өдрөөс 8 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулж байна.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

- Сумын ИТХ-ын 21 төлөөлөгчдөд тус бүрдээ 76 хуудастай “Харилцах дэвтэр” нээж өгсөн бөгөөд уг дэвтэрт төлөөлөгчийн гар утас, орон нутгийн төрийн албан хаагчдын утасны жагсаалт, хөтлөх журмыг хавсаргасан байдаг.
- БИНХ-д оролцох оролцоо нэмэгдэж, баг орон нутагт тулгамдаж буй асуудлаар оновчтой, санал шийдлийг гаргасан 1 иргэнд гэрчилгээ олгодог
- Үйл ажиллагаа явуулах зардлыг сумын ИТХ-ын тухайн оны төсөвт суулгадаг.Төлөөлөгчид сонгогчдодоо тайлангаа тавьж,санал хүсэлтийг сонсон, Спорт-урлагийн тэмцээн уралдаан зохион байгуулдаг

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- Багийн өдөрлөгөөр нийт 4 малчныг Итгэлт хамба, байгаль далайд аялах эрхээр шагнав. Ажлыг төлөөлөгчдөд санал болгож, зохион байгуулав.
- “ГЭР ЦЭЦЭРЛЭГ”-ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор жил бүр 400 000 төгрөгийн санхүүжилт хийв.
- 2019 оны төлөөлөгчийн өдөрлөгөөр хүүхдүүдэд бэлэг гардуулахаар 200 000 гаруй төгрөгийг санхүүжүүлэв.
- Баянбадрал багийн ИНХ-ын үйл ажиллагааг дэмжих зорилгоор 285 000 төгрөгийг төсөвт тусгав.
- Баянбадрал багийн өндөр настан Гэрэлмаад тусламж үзүүлэхээр аймгийн Засаг даргад хүсэлт гаргав.
- БИНХ-д идэвхтэй оролцож баг, болон орон нутагт тулгамдаж байгаа асуудлаар оновчтой санал гаргадаг иргэдийг урамшуулав.



- Сумын ИТХ-ын "Төлөөлөгчдийн өдөрлөг"-өөр иргэдэд сумын ИТХ-с батлан гаргасан тогтоол шийдвэрийг болон Монгол улсын шинээр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг мэдээлэв.
- ИТХ-н харилцах дэвтэр ажиллуулан иргэдээс гарсан саналуудыг нэгтгэн Засаг дарга болон бусад холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэн, төсөл хөтөлбөр, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд нь тусгуулан ажиллах

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Үйл ажиллагаа явуулах зардлыг сумын ИТХ-ын тухайн оны төсөвт суулгадаг ба 2019 оны хувьд төлөөлөгч тус бүрд 50000 төгрөгөөр тооцож, байгууллагынхаа мэдээлэл сурталчилгааны зардалд тусган батлуулсан бөгөөд зарим уралдаан тэмцээний зардлыг төлөөлөгчид өөрсдөө гаргах, малчдаас хандив авах, багийн сангаас шийдэх зэргээр санхүүжилтийг шийддэг. Санхүүжилтийн нийт зардал 1.1 сая.

ХҮРСЭН ҮР ДҮН

- 4 малчин иргэн 2019 оны 9 сард аялалдаа яваад ирсэн.
- Гэр цэцэрлэгийн үйл ажиллагааг дэмжин хаалтын үйл ажиллагааг хамтран зохион байгуулж ажилласан.
- 200 000 гаруй төгрөгөөр 40 гаруй хүүхдэд бэлэг гардуулав.
- Баянбадрал багийн ИНХ-ын үйл ажиллагааг дэмжих зорилгоор 285000 төгрөгийн үнэ бүхий чанга яригч, өсгөгчийн хамт өөрийн хөрөнгөөр авч багийн даргад гардуулж өгсөн.
- Аймгийн засаг даргад хүсэлт гарган Баянбадрал багийн өндөр настан Гэрэлмаад гэр олгуулах, багийн иргэдээс хандив цуглуулан нийт 1 200 000 гаруй төгрөгийг гардуулах өгч гэртэй болгов.
- БИНХ-д идэвхтэй оролцож баг, болон орон нутагт тулгамдаж байгаа асуудлаар оновчтой санал гаргадаг иргэдийг "Идэвхтэй оролцогч иргэн" гэрчилгээг олгож хэвшээд байна.
- Сумын ИТХ-ын "Төлөөлөгчдийн өдөрлөг"-өөр иргэдэд сумын ИТХ-с батлан гаргасан тогтоол шийдвэрийг болон Монгол улсын шинээр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг сурталчлан, иргэдийн дунд төрөл бүрийн урлаг спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Бэрхшээл, эрсдэл гараагүй ба иргэд дэлгэр зуны цагт баг дээрээ цуглан, мэдээлэл авахын зэрэгцээ тэмцээн уралдаан зохиож нэг өдрийг хөгжилдөн өнгөрөөдөг.

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

1. ИТХ-ын үйл ажиллагааны талаар иргэд мэдээлэлтэй болж, төлөөлөгчдийн үйл ажиллагааг олон нийтэд хүргэсэн.
2. Нутгийн төлөөллийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо нэмэгдсэн.
3. Өдөрлөгийн үйл ажиллагааг зохион байгуулах явцад иргэд багаар ажиллах, багийн зохион байгуулалтад оролцох туршлага нэмэгдсэн.



8. Дорнод аймгийн Чойбалсан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

“ИРГЭДИЙГ ИДЭВХЖҮҮЛСЭН НЬ”**САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ**

Ц.БАЯРЦОГТ, Дорнод аймгийн Чойбалсан сумын ИТХ-ын дарга. Цахилгаан, техникч мэргэжилтэй. 2004-2008 онд Сумын ИТХ-д Төлөөлөгч, 2008-2012 онд Сумын ИТХ-д Төлөөлөгч, 2012-2016 онд Аймгийн ИТХ-д Тэргүүлэгчээр тус тус сонгогдсон. 2016 оноос сумын Чойбалсан сумын ИТХ-ын даргаар ажиллаж байна.

Холбоо барих утас: 95741133, Цахим хаяг: turuu_21@yahoo.com

АГУУЛГА

Чойбалсан сумын иргэд нь орон нутгийн ИТХ-аас шийдвэр гаргах үйл явцад оролцдоггүй, санал бодлоо хуваалцах нь хангалтгүй байдаг тул иргэдийн оролцоог сайжруулах ажлуудыг хийсэн.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. дэх заалтад “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурал нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий хороог байгуулан ажиллуулж Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангана” гэж заасан байдаг хэдий ч хэрэгждэггүй байсан. ИТХ-аас гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, эргэх холбоо сул байсан. Орон нутгийн иргэд шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох идэвх муу байсан.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Дорнод аймгийн Чойбалсан сумын иргэдэд чиглэсэн.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2018-2019 онд хэрэгжүүлэв.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

Сумын ИТХ-ын шийдвэр гаргах ажиллагаанд иргэний оролцоог хангах журам боловсруулан, батлуулж дагаж мөрдөж байсан. Уг журмыг 15 иргэн сайн дурын үндсэн дээр хуулийн зөвлөх багтай хамтран ажиллаж иргэд, төрийн болон төрийн байгууллагын төлөөллөөр хэлэлцүүлэн гаргаж ирсэн.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- “Сумын ИТХ-ын шийдвэр гаргах ажиллагаанд иргэний оролцоог хангах журам” баталсан.
- Сумын ИТХ-ын төсөв батлах хуралдаанд иргэдийг оролцуулж саналыг сонссон. /зураг/
- Нутгийн удирдлага, өргөдөл гомдол, хяналт үнэлгээ, төсөв эдийн засаг, нийгэм, эрдэс баялаг, үйлдвэр, хүнс хөдөө аж ахуй, зам тээвэр, эрчим хүч, газрын харилцаа, хот байгуулалт, байгаль орчин, аялал жуулчлал, гадаад харилцааны 8 бодлогын хороо байгуулан, Төлөөлөгчдийг өөрсдийнх саналаар 1-2 бодлогын хороонд хамруулан



ажиллуулав. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг хуралдааны өмнө хэлэлцэн тогтоолын шийдвэрийн төслийг боловсруулав.

- Төсөв эдийн засгийн бодлогын хороо нь орон нутгийн төсөв, санхүүгийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд анхаарч, Нийгмийн бодлогын хороо нь хүн амын эрүүл мэнд, боловсрол, ахуйн үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх, өрхийн амьжиргааг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн мэргэжлийн байгууллагын тайлан мэдээг сонсож, үнэлэлт дүгнэлт өгөв.
- Эрдэс баялгийн хороо нь Хурлын байгууллагаас эрдэс баялаг, уул уурхай, газрын тосны чиглэлээр баримталж буй бодлого чиглэл, аймгийн хэмжээнд уул, уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын үйл ажиллагаанд хяналт тавьж гаргасан зөрчлийг арилгуулах талаар үүрэг чиглэл өгч ажиллав. Үйлдвэр хүнс хөдөө аж ахуйн бодлогын хороо нь жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, иргэдийг төсөл хөтөлбөрт хамруулах, газар тариалан мал аж ахуйг хөгжүүлэх талаар гаргасан тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үндсэн чиглэлд тусгагдсан ажилд үнэлэлт дүгнэлт өгөв.
- Зам тээвэр, эрчим хүч, газрын харилцаа, хот байгуулалтын бодлогын хүрээнд орон сууц хөтөлбөрийн хэрэгжилт, аймгийн төвийг орон нутагтай холбох хэтийн төлөвийн талаар хэлэлцэн, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагаанд хяналт тавьж, үндсэн чиглэлийн заалтын хэрэгжилтийг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгөх зэрэг олон ажлыг санаачлан хийлээ.
- Байгаль орчин, аялал жуулчлал, гадаад харилцааны бодлогын хүрээнд гадаад худалдааны тааламжтай нөхцөлийг судлах, Дорнод аймгийн хилийн боомтуудын хяналтын байгууллагын үйл ажиллагаатай танилцах, хөрш зэргэлдээ улсын бүс нутгийн хэмжээнд албан харилцаагаа сайжруулах, нутгийн өөрөө удирдах байгууллагатай хамтран ажиллах, туршлага солилцох ажлыг зохион байгуулан ажиллаа.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Сум орон нутгаас санхүүгийн эх үүсвэр гараагүй болно.

ХҮРСЭН ҮР ДҮН

- Иргэдийг шийдвэр гаргах ажиллагаанд оролцуулж санал бодлыг тусгадаг болсон.
- 2016-2020 оны бүрэн эрхийн хугацаанд Хурлын хороодын үйл ажиллагаанд анхаарч ажилласнаар хороодын үйл ажиллагаа сайжирч, Хурлын хуралдааны өмнө хэлэлцэх асуудлыг нягтлан хэлэлцэж, хуралдаанд оруулж хэвшлээ.
- Гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр 2016-2020 онуудад 15 ажлын хэсэгт давхардсан тоогоор 33 төлөөлөгч орж ажилласан.
- Төлөөлөгчдийн оролцоотой байгуулагдсан ажлын хэсгүүд нь уул уурхай, газрын тосны салбарт нутгийн иргэдийн оролцоог хангах, ажлыг байрыг нэмэгдүүлэх зэрэг орон нутгийн тулгамдсан асуудлаар тухайн сум, оронд ажиллаж нийгмийн өмнө тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэсэн.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

- Сайн дураар ажилласан 15 сургагч багш болон иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг байсан,
- Хөрөнгө мөнгө болон төсөв санхүү дутмаг учраас сайн дурын 15 сургагч багш сайн дурын үндсэн дээр ажиллаж байсан.
- Сумын ирээдүй болсон залуучуудын идэвх оролцоо муу байсан.



СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Иргэд иргэний оролцооны талаар мэдлэг, мэдээлэлтэй болсноор эрх үүргээ ухамсарлах болсон.

Иргэд, төлөөллийн байгууллагын хооронд хариуцлагын тогтолцоо бий болж, хамтын ажиллагааны уялдаа холбоо сайжирсан.

“Сумын ИТХ-ын шийдвэр гаргах ажиллагаанд иргэний оролцоог хангах журам” баталсан нь аливаа асуудалд иргэд саналаа дэвшүүлснээр, иргэдийн эрх ашигт нийцсэн бодлого шийдвэр гарч, төлөөллийн байгууллагын үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах болсон.

Хавсралт 1. Сумын ИТХ-ын шийдвэр гаргах ажиллагаанд иргэний оролцоог хангах журам батлах тухай 04 дүгээр тогтоол

ДОРНОД АЙМАГ
ЧОЙБАЛСАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 8-Р ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2018 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 04

Хуудай

Г Журам батлах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр гаргах ажиллагаанд иргэний оролцоог хангах журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг Хууль зүй дотоод хэргийн яаманд бүртгүүлж мөрдлөгө болгон ажиллахыг сумын Засаг дарга /Ц.Ариунболд/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  Ц.БАЯРЦОГТ

29 075

Хавсралт 2. Сумын ИТХ-ын шийдвэр гаргах ажиллагаанд иргэний оролцоог хангах журам

Чойбалсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
ээлжит 8-р хуралдааны 04 дугаар тогтоолын хавсралт

СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР ГАРГАХ АЖИЛЛАГААНД ИРГЭНИЙ ОРОЛЦООГ ХАНГАХ ЖУРАМ

1 дүгээр зүйл. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмыг Чойбалсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /цаашид Хурал гэх/ -ын шийдвэр гаргах ажиллагаанд сумын иргэдийн шууд оролцоог хангах арга хэрэгслийг нарийвчлан зохицуулахад оршино.

1.2. Хурлын шийдвэр гэдэгт Үндсэн хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхээр гаргасан нийтэд чиглэсэн, тэдний эрх ашгийг илэрхийлсэн акт, гэрээ, захиргааны хэм хэмжээний актыг ойлгоно.

1.3. Иргэний шууд оролцоог хангана гэдэг нь нэг талаас Хуралд хэлэлцэх асуудлаар иргэний санал гаргах /цаашид санал гаргах гэх/ эрх, нөгөө талаас эрх ашиг нь хөндөгдсөн этгээдээс тайлбар авах, зөвлөлдөх замаар хамтран ажиллах, мэдээлэл өгөх Хурлын үүргээр тодорхойлно.

1.4. Иргэн гэдэгт суманд оршин суух бүрдгэлтэй хуульд заасан насанд хүрсэн хүн, хуулийн этгээд орно. Мөн суманд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг тооцно.

1.5. Хурал шийдвэр гаргах ажиллагаандаа иргэний оролцоог хангахдаа Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (цаашид ЗЗНДНТУТХ гэх), Захиргааны Ерөнхий хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Төсвийн тухай хууль, Мэдээлэл авах, мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуульд заасан журмыг үндэслэнэ.

1.6. Иргэний хувийн ашиг сонирхолтой холбоотой гомдол маргааныг шийдвэрлэхэд энэ журам үйлчлэхгүй.

1.7. Хурлын хуралдааны явц дах иргэний оролцоог хангах зохицуулалтыг Дэгээр зохицуулах тул энэ журамд хамаарахгүй.

2 дугаар зүйл.Оролцооны зарчим

2.1. Иргэн санал, тайлбар гаргах эсэхээ чөлөөтэй, бие даан шийдвэрлэх бөгөөд хэн боловч хөндлөнгөөс нөлөөлөх,саад учруулахыг хориглоно.

2.2. Хурал нь иж бүрэн, хараат бус, ил тод, ойлгомжтой,тэнцвэртэй мэдээллээр иргэдийг хангана.

3 дугаар зүйл. Хуралд асуудал санаачлах этгээдэд иргэний санал гаргах эрх

3.1 ЗЗНДНТУТХ-ийн 24 дүгээр зүйлийн 1-д заасан эрх бүхий этгээдэд (цаашид асуудал санаачлах этгээд гэх) сумын иргэн энэ хуулийн 24 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу санал гаргах эрхтэй.

3.2. Иргэн санал гаргах гэдэгт нутаг дэвсгэрийнхээ нийгэм-эдийн засгийг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан санал, сумын иргэдийн нийтлэг ашиг сонирхлыг хөндөж буй Хурал, түүний Тэргүүлэгчид болон Засаг даргын шийдвэр, үйл ажиллагааны талаар тайлбар гаргуулах, орон нутгийн тулгамдсан асуудлыг нэн даруй шийдвэрлүүлэхийн тулд гаргасан хүсэлтийг ойлгоно.



Тайлбар: орон нутагт тулгамдсан асуудал гэдгийг сумын иргэдийн эрх, ашиг сонирхол, аюулгүй байдал, усны хомсдол, бэлчээр ашиглалт, байгалийн болон бусад гамшигт байдалд хүрсэн байхыг хэлнэ.

3.3. Орон нутгийн төсвийг хэлэлцэхэд иргэний санал гаргах эрхийг Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлд заасны дагуу Хурал ханган ажиллана.

3.4 Хурлын хуралдаанаас гаргасан тогтоол, Тэргүүлэгчид, Хорооноос гаргаж буй шийдвэрийн талаар мэдээлэл авах эрхийг санал гаргах эрхтэй адилтган үзнэ.

4 дүгээр зүйл. Хурлын тогтоолын төсөл боловсруулахад иргэний оролцоог зохион байгуулах

4.1. Асуудал санаачлах этгээд тогтоолын төсөл боловсруулах ажилд иргэний оролцоог дараах үе шаттайгаар зохион байгуулна.

4.1.1. эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх сумын иргэн, хуулийн этгээдийн төлөөллөөр тогтоолын төслийг хэлэлцүүлж, тайлбар авах;

4.1.2. багийн нийтийн Хурлаар хэлэлцүүлэг зохион байгуулж санал, хүсэлтийг авах

4.1.3. тогтоолын төсөлд холбогдох орон нутгийн төрийн бус байгууллага, мөн улсын хэмжээний судалгааны байгууллагаас санал авч, төсөл боловсруулахад харгалзан үзнэ.

4.1.4. тогтоолын төсөлд холбогдох асуудлаар түр хороо, ажлын хэсэг, зөвлөлийг байгуулж, иргэний төлөөллийг байлцуулна. Иргэний төлөөлөлд баг тус бүрийн Хурлын Тэргүүлэгчдээс санал болгосон насанд хүрсэн нэг иргэнээс бүрдсэн жагсаалтыг сумын Хурлын Тэргүүлэгчид жил бүр шинэчлэн батална. Жагсаалтад багтсан иргэн сумын Тэргүүлэгчдийн санал болон өөрийн хүсэлтээр түр хороо, ажлын хэсэг, зөвлөлд оролцоно.

4.2. Асуудал санаачлах этгээд иргэнээс бичгээр болон биечлэн уулзах замаар гаргасан санал, тайлбар, хүсэлтийг хүлээн авч тогтоолын төслийн хувийн хэрэгт оруулна. Хувийн хэргийг бүрдүүлэхдээ Захиргааны Ерөнхий хуульд заасан журмыг баримтална.

4.3. Тогтоолын төсөлд иргэний саналыг заавал тусгах шаардлагагүй ч аваагүй шалтгаанаа иргэнд асуудал санаачлах этгээд мэдээлэх үүрэгтэй.

4.4. Иргэн санал, тайлбар, хүсэлтээ Хурлын даргад хэдийд ч гаргаж болно.

4.5. Хурлын дарга асуудал санаачлах этгээдэд иргэний гаргасан санал, тайлбар, хүсэлтийг ажлын тав хоногийн дотор хүргүүлнэ.

4.6. Энэ журамд заасан иргэдийн оролцоог хангах, зар мэдээлэл хүргэх зардлыг сумын жил бүрийн төсөвт суулгаж батална.

4.7. энэ журмын 4,5 дугаар зүйлд заасан зохион байгуулалтын ажлыг Засаг даргын тамгын газрын Иргэний оролцоо хариуцсан мэргэжилтэн хариуцан ажиллана. Иргэний оролцоо хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг засаг дарга батална.

5 дүгээр зүйл. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаар нийтэд зарлах

5.1. Хурлын Нарийн бичгийн дарга Хуралдаанаар хэлэлцэх асуудлын сэдэв, өдөр, цагийн тухай зарыг байгууллагын цахим хаяг, мэдээллийн ба зарын самбар, хүн олноор цуглардаг, өдөр тутамд үйлчилгээг нь авдаг үйлчилгээний байгууллагын зай талбай (хүнсний зах, худаг, сургууль, эмнэлэг гэх мэт), орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, шаардлагатай бол гар утасны мессежээр нийтэд мэдээлнэ.

5.2. Хуралд хэлэлцэх асуудал, хурлын шийдвэр, үйл ажиллагаа, түүний хэрэгжилтийн талаар тогтмол мэдээллийн хуудас гаргаж сумын нийт иргэдэд хүргэнэ.



5.3. Тогтоолын төсөлд санал, тайлбар, хүсэлт гаргасан иргэнд зарын мэдэгдлийг биечлэн гардуулж өгнө.

5.4. Асуудал санаачлах этгээд тогтоолын төслийг ЗЗНДНТУТХ-ийн 24 дүгээр зүйлийн 3-д заасны дагуу төлөөлөгчдөд тараах бөгөөд олон нийтэд ажлын таваас доошгүй хоногийн өмнө мэдээлнэ.

6 дугаар зүйл. Хурлын шийдвэр гаргах ажиллагаанд иргэний оролцоог хангахтай холбоотой хариуцлага

6.1. Иргэн, асуудал санаачлах этгээд болон Хурлын дарга санал гаргах эрхийг нь зөрчсөн гэж үзвэл холбогдох хуульд заасны дагуу Хуралд өөрт нь гомдол гаргах эсхүл шүүхэд нэхэмжлэх гаргана.

9. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

“МИНИЙ ОРОЛЦОО-МИНИ ХУРАЛДААН”**САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ**

Т.БЭРЦЭЦЭГ, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга.

Сумын эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга, УЗАШ Хорооны нарийн бичгийн даргын сонгуульт ажлыг хийдэг.

2009 оноос ИТХ-ын нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

Холбоо барих утас: 86068184

Цахим хаяг: bertsetseg2016@gmail.com

АГУУЛГА

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулалт хийж тэдний санал хүсэлтийг авснаар “Миний оролцоо- Мини хуралдаан” үүсгэн, хүүхдүүдийн нийгмийн идэвх оролцоог сайжруулахын зэрэгцээ тэдний дуу хоолойг орон нутгийн бодлого боловсруулагч нарт хүргэж байна.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЕБС-ийн сурагчид ялангуяа өсвөр насныхан тэдний өмнө тулгамдаж буй асуудлын хүрээнд санал бодлоо хуваалцах, асуудлыг шийдэх арга замыг эрэлхийлэх байдал тулгамдаж байсан. Мөн хүүхдийн асуудлыг шийдэх, ирээдүйн шилдэг боловсон хүчин бэлтгэхэд нийгмийн оролцоог дэмжсэн үйл ажиллагаа дутмаг байсан.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Өмнөдэлгэр сумын ЕБС-ийн 8-12-р ангийн сурагчдыг хамруулав.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2019 оны 10-р сараас 2019 оны 12-р сар хүртэлх хугацаанд хэрэгжүүлэв.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

Санал хүсэлтийн хайрцагаар ирүүлж байгаа саналын 25 хувийг ЕБС-ын 9-12-р ангийн сурагчдын санал, хүсэлт эзэлж байгаад дүгнэлт хийн тэднийг сонсох, санал хүсэлтийг хүлээн авах, асуудлыг шийдвэрлэх зорилгоор ДЗОУБ-д хүсэлт тавьж Иргэдийн дуу хоолой аргачлалын дагуу “Миний оролцоо-Мини хуралдаан” зорилтот ажлыг хийлээ.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- Охидын эрхийн асуудалд анхаарал хандуулах, энэ талаарх олон нийтийн ойлголт мэдээллийг нэмэгдүүлэх, охидод эрхээ хамгаалахыг уриалах, охидыг сонсох, асуудлыг шийдвэрлэх арга замыг бий болгох зорилгоор “Охидоо сонсьё” зөвлөгөөнийг хийж 165 охид хамрагдан санал хүсэлтийг хүлээн авлаа.
- Хөвгүүдийн эрхийн асуудалд анхаарал хандуулах, тэднийг сонсох асуудлыг шийдвэрлэх арга замыг бий болгох зорилгоор “Хөвгүүдийн манлайлал-Оролцоо” зөвлөгөөнийг зохион байгуулж 67 хөвгүүд оролцон санал хүсэлтээ тавилаа.
- Хүүхэд эрхээ эдэлж, үүргээ биелүүлдэг эрх зүйт төртэй улсын иргэн болохыг ойлгуулах, ирээдүйдээ итгэх итгэлийг нэмэгдүүлэх, урам зориг өгөх, дуу хоолойг сонсох, санал санаачилгыг үнэлэх урамшуулах, дэмжих, хүүхдийн өмнө тулгамдаж буй



асуудлыг өөрсдийн оролцоотойгоор тодорхойлуулах, шийдвэрлэх замаар нутгийн өөрөө удирдах байгууллагын ач холбогдол, үйл ажиллагааг сурталчлан таниулахад зорилгоор “Миний хуралдаан гэж юу юу?” танилцуулах ажлыг 8-12-р ангийн 13 бүлгийн 390 хүүхдэд хийсэн.

- ЕБС-ийн 8-12 –р ангийн 44 сурагчид нэрээ дэвшүүлэн сонгуулийн зарчмаар оролцон 27 төлөөлөгч сонгогдон 970 хүүхэд болон сургуулийн орчимд тулгамдаж асуудлуудыг тодорхойлон гаргаж хуралдаанаараа хэлэлцэн ажиллаж байна.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Охид хөвгүүдийн зөвлөгөөнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас, Миний оролцоо-“Мини хуралдаан”-ыг Дэлхийн Зөн Олон Улсын байгууллагын “Иргэдийн оролцоо” төслөөс санхүүжүүлэн нийт 1.598.050 төгрөг зарцуулсан.

ХҮРСЭН ҮР ДҮН

- Байгууллага бүр нийгмийн хариуцлагын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг болон хүүхдүүдийг нийгмийн харилцаанд орох ээлтэй орчин бий болгох зорилгоор тохижилт хийх, Хүүхдийн аюулгүй байдлыг хангаж айл өрх бүр хашаандаа гэрэл тавих, гудамжны камертай болох,
- Сургуулийн орчинд хориглосон хүнсний жагсаалтыг хэрэгжүүлэн ажиллах, ногоон хоолны бүстэй болох,
- Стандартад тохирсон цайны газартай болох,
- Сургуулийн орчин дахь ухаалаг утсыг хориглосон шийдвэрийг хэрэгжүүлэх,
- Цахим хэрэглээний донтолттой хүүхдүүдэд сэтгэл зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх
- Хүүхдийн оролцооны байгууллагуудын нэгдсэн чуулганыг хийж “Мини хуралдаан”-аас гарсан саналуудыг хүүхдийн оролцоотой хийж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, уриалга гаргах хэрэгжүүлэн ажиллах, тухайн байгууллагуудын үйл ажиллагааг тогтворжуулах, чиглүүлэгч багш нарыг идэвхжүүлэх,
- Хүүхдүүд, эцэг эхчүүдийг зөвд уриалсан, эерэг хандлагыг бий болгосон төрөл бүрийн сургалтуудыг тогтмол хийх,
- Дотуур байрны угаалгын өрөөг тохижуулж, ариутгал тогтмол хийх, усанд орох боломжийг нэмэгдүүлэх, тогтмолжуулах,
- Гал тогооны тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, ундны усны савыг стандартын болгох, ундны халуун буцалсан усыг байнга байлгах,
- Төрийн албан хаагчдыг хүүхдэдээ тавих анхаарлыг нэмэгдүүлж, эцэг эхийн хуралд суулгах, амралт, баяр ёслолын үеэр амраах, гэр бүлийн өдрөөр гэр бүлтэй нь хамт байх ажил зохион байгуулах, хамт олноороо тэмдэглэдэг баяр, нийллэгийг цөөлөх,
- Эцэг, эхийн зөвлөгөөнийг хийх, ирцийг бүрдүүлэхэд багш нар, хүүхэд бүр анхаарах,
- Архи, тамхийг хүүхдэд огт худалдаалахгүй байх зэрэг ажлуудыг тусган ажиллаж байна.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Санхүүгийн бэрхшээл тулгамдаж байсан.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

Өмнөдэлгэр сумын нутгийн удирдлагууд ирээдүйн түүчээ болсон хүүхдүүдийн өмнө тулгамдаж буй асуудлыг сонсон, шийдвэрлэж өгөх арга замыг хайж байгаад үнэхээр их талархаж байна.

Өмнөдэлгэр сумын ЕБС-ийн сурагч Т.Чингүүн



Энэхүү ажлын зохион байгуулалт, эцэс-эл, баста, бүрэлдэвч үндэслэлүүд, нийгмийн ажлын тусламж дэмжлэг маш их хэрэгтэй бөгөөд эдгээр хүмүүсийн хамтын сэтгэл зүрх, үйл ажиллагааны үр дүнд сурагчдыг гэмт хэргээс илүү их урьдчилан сэргийлж чадаж байна.

Өмнөдэлгэр сумын ЕБС-ийн сурагч М.Сод-Ирээдүй

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Орон нутгийн иргэд болон хүүхдүүдийн нийгмийн идэвх оролцоо, санал санаачилга сайжирсан.

Хүүхдүүд тэдэнд тулгамдаж буй асуудал болоод цаашид хийгдээсэй гэж хүсэж буй зүйлийнхээ талаар санал бодлоо бусдад хуваалцаж сурсан.

Хүүхдүүдийн өөртөө итгэх итгэл, өөрийгөө илэрхийлэх чадамж, бусдыг сонсох, хүндлэх, багаар ажиллах гэх мэт олон ур чадварт суралцсан.

Хүүхэд, эцэг эхчүүд, асран хамгаалагчдын архи, тамхины хор нөлөө, нийгэм дэх сөрөг үр дагаврын талаарх мэдлэг, мэдээлэл нэмэгдсэн.

Төрийн болон төлөөллийн байгууллага нь хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, нийгэмд тэдний дуу хоолойг хүргэхэд ямар үйл ажиллагаа зохион байгуулах хэрэгцээ шаардлагатай байгааг илүү сайн мэдэх боломж бүрдсэн.

Хавсралт 1. Төлөөлөгчөөр сонгогдсонд тооцох тухай 01 дүгээр тогтоол



ХЭВТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 01

Айрагийн Эгнэр

Төлөөлөгчөөр сонгогдсонд тооцох тухай

"Иргэдийн дуу хоолой" хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй "Миний оролцоо - Мини хуралдаан"-ы төлөөлөгч сонгох сонгуулийн хорооноос ТОГТООХ НЬ:

1. Хүүхэд эрхээ эдэлж, үүргээ биелүүлдэг эрх зүйт төртэй улсын иргэн болохыг ойлгуулах, ирээдүйдээ итгэх итгэлийг нэмэгдүүлэх, урам зориг өгөх, дуу хоолойг сонсох, санал санаачилгыг үнэлэх урамшуулах, дэмжих, хүүхдийн өмнө тулгамдаж буй асуудлыг өөрсдийн оролцоотойгоор тодорхойлуулах, шийдвэрлэх замаар нутгийн өөрөө удирдах байгууллагын ач холбогдол, үйл ажиллагааг сурталчилан таниулах зорилго бүхий Мини хуралдааны төлөөлөгчдийг сонгуульд хамгийн олон санал авсан нэр дэвшигчдийг хурлын төлөөлөгчөөр сонгогдсонд тооцсугай.
2. Хурлын төлөөлөгчдийн нэрсийг 1-р хавсралтаар баталсугай.
3. Хурлын төлөөлөгчдийн нэрсийг сумын ИХТ-д хүргүүлэх ажлыг сонгуулийн хорооны нарийн бичгийн дарга /М.Нямханд/-д даалгасугай.

ДАРГА *О. Болортунгагал* О.БОЛОРТУНГАЛАГ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *М.Нямханд* М.НЯМХАНД

Хавсралт 2. Төлөөлөгчөөр сонгогдсонд тооцох тухай 01 дүгээр тогтоолын хавсралт

"Миний оролцоо-Мини хуралдаан"

БАТЛАВ



ӨМНӨДӨЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХҮРЛЫН ДАРГА

А.ДАВААДОРЖ

"ДЗМОУБ-ЫН БОР-ӨНДӨР-2
ОНХХ-ИЙН БАГИЙН АХЛАГЧ

Г.ЖАРГАЛБАТ

"ИРГЭДИЙН ДУУ ХООЛОЙ" ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ

"МИНИЙ ОРОЛЦОО-МИНИ ХУРАЛДААН"

ЗОРИЛТОТ АЖЛЫН УДИРДАМЖ

2019.11.15

Айрагийн энгэр

Нэг. Зорилго

Хүүхэд эрхээ эдэлж, үүргээ биелүүлдэг эрх зүйт тэртэй улсын иргэн болохыг ойлгуулах, ирээдүйдээ итгэх итгэлийг нэмэгдүүлэх, урам зориг өгөх, дуу хоолойг сонсох, санал санаачилгыг үнэлэх урамшуулах, дэмжих, хүүхдийн өмнө тулгамдаж буй асуудлыг өөрсдийн оролцоотойгоор тодорхойлуулах, шийдвэрлэх замаар нутгийн өөрөө удирдах байгууллагын ач холбогдол, үйл ажиллагааг сурталчилан таниулахад оршино.

Хоёр. Зохион байгуулагч, дэмжигч

Энэхүү зорилтот ажлыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Дэлхийн зөн Монгол ОУБ-ын Бор-Өндөр-2 ОНХХ-ийн баг, Ерөнхий боловсролын сургууль хамтран зохион байгуулна.

Гурав. Шалгуур, оролцоо

ИТХ-ын ажлын алба 8-12-р ангийн сурагчидтай ярилцага хийж олонхи сурагчдын саналын дагуу дараах үе шаттайгаар буюу сонгуулийн зарчмаар зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Үүнд:

1-р үе шат. Ерөнхий боловсролын сургуулийн 8-12-р ангийн сурагчид 2019 оны 11 сарын 25-28-ны хугацаанд нэрээ дэвшүүлж танилцуулгаа хийнэ.

2-р үе шат. Мини хуралдаанд 8-р ангиас 3, 9-р ангиас 3, 10-р ангиас 8, 11-р ангиас 8, 12-р ангиас 5 сурагч суух бөгөөд 27 сурагчийг \ төлөөлөгчийг \ сонгох сонгууль 2019 оны 11 сарын 31-ны өдрийн Ням гарагийн 10.00 цагаас Спорт зааланд явагдана.

3-р үе шат. Сонгогдсон 27 төлөөлөгч 2019 оны 12 сарын 01-04-ны хугацаанд сургуулийн хүүхдүүдийн дунд тулгамдаж буй асуудлуудыг нийт сурагчдын оролцоотойгоор тодорхойлж, судалж гаргасан байна.



Хавсралт 3. Иргэдийн дуу хоолой хөтөлбөрийн хүрээнд хийгдэх “Миний оролцоо-Мини хуралдаан” зорилтот ажлын удирдамж

4-р үе шат. Нийт 27 Төлөөлөгч 2019 оны 12 сарын 11-ны өдрийн 09.00 цагт Нутгийн удирдлагын ордонд хуралдана.

Дөрөв. Бусад

Хуралдааны бэлтгэл, сургалт, хэлэлцэх асуудлыг нэгтгэх ажил, Хурлын хуралдаан зэргийг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.

Хуралдаанаас гарсан үр дүн, шийдвэрийг сумын шийдвэр гаргах түвшний албан тушаалтан, байгууллагад хүргүүлж ажиллана.

Хуралдаанд болон Төлөөлөгчдөд шаардагдах зардлыг ДЗМОУБ-ын Бор-Өндөр-2 ОНХХ-ийн баг санхүүжүүлнэ.

СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН АЖЛЫН АЛБА

10. Ховд аймгийн Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал**“ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДЭЖ БУЙ БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ”****САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ**

П.ОЮУНТУНГАЛАГ, Ховд аймгийн Жаргалант сумын ИТХ-ын Нарийн бичгийн дарга. “Худалдааны зохион байгуулагч, бараа судлаач” мэргэжилтэй. 2004-2010 оны хооронд 2 удаа Жаргалант сумын Бугат багаас сумын ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байсан.
Холбоо барих утас: 99744705,
Цахим хаяг: Tsoqlog.aagii@yahoo.com

АГУУЛГА

Ховд аймгийн Жаргалант сумын ИТХ-ын санаачилгаар ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй бараа, ажил үйлчилгээнд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор иргэдийг танхимын сургалтад хамруулан чадавхжуулан, иргэдийн оролцоог дэмжсэн.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй бараа, ажил үйлчилгээ нь шаардлагад нийцдэггүй, зураг төсвийн дагуу хийгдэж чаддаггүй, гаргасан шийдвэр нь оновчтой бус, иргэдийн саналаар багаас эрэмбэлсэн асуудлууд хийгдэхгүй байгаа, иргэдийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэж чадахгүй байгаагаар холбоотой иргэдээс ирж буй өргөдөл гомдол нь тулгамдсан асуудал болоод байна.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Сумын ИТХ, Тогтвортой амьжиргаа-3 төсөл, хамтран анхны сургалтыг, Багийн засаг дарга, ОНХС-ийн мэргэжилтэн, ИНХ-ын дарга, Тэргүүлэгчид, Сумын ИТХ-ын төлөөлөгч, ИТХ-ын дэргэдэх хяналтын хорооны гишүүд, сургагч багш 12 багийн иргэдийг оролцуулан сургалт зохион байгуулсан.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2018 оны 10 сард хэрэгжүүлсэн.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй бараа, ажил үйлчилгээнд хэрхэн хяналт тавих ёстой. Ямар дүрэм журмыг баримтлан ажлууд хийгддэг зэрэг мэдээллийг иргэдэд хуулийн хүрээнд багш нараар сургалтын хэлбэрээр заалган хэлэлцүүлгийг зохион байгуулан явуулсан.

2018.10.10-2018.10.18 хооронд сумын ИТХ-ын төлөөлөгч, БЗД, БИНХ-ын дарга, тэргүүлэгч болон 300 гаруй иргэнд ОНХС-ийн хөрөнгөнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, иргэний бүлэг байгуулах хянах аргачлалд сургах, 12 баг тус бүрд 5 хүний бүрэлдэхүүнтэй хяналтын бүлгийг байгуулан ажиллуулсан. Сургалтын явцад 320 гаруй иргэнээс хяналт-шинжилгээ үнэлгээний үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх нь шинэлэг санаачилга үнэлгээний судалгааг авч дүгнэж үр дүнгийн тооцож гаргав. Сургалтын явцад сумын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороог ИТХТ-ийн 164 дүгээр тоот тогтоолоор байгуулж, хяналт шалгалтын удирдамж гарган 2017-2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийж хэрэгжүүлэх ажилд хяналт шинжилгээ хийж байна. Сургалтаар иргэдэд



сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ажлын төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавих ИТХ-ын дэргэдэх хяналтын хорооны ажиллах журам, сумын ОНХС-ийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэлд иргэдийн оролцоотой хяналт тавих журмыг иргэдээр хэлэлцүүлсэн.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй бараа, ажил үйлчилгээ гэж юу вэ? ОНХС-ийн талаарх онолыг иргэдэд сургагч багшаар дамжуулан 7 хоногийн турш сургалт хэлбэрээр зохион байгуулж тэдэнд тодорхой ойлголтыг хүргэсэн.
- ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй бараа, ажил үйлчилгээнд хяналт тавихад иргэдийн оролцоо ямар чухал гэдгийг мэдээлэл, гарын авлага зэргээр хүргэсэн.
- ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажил, үйлчилгээнд иргэд хэрхэн оролцох талаарх хэлэлцүүлэг явуулж иргэдээс судалгаа авч гарсан үр дүнг танилцуулан ажилласан.



Ховд аймгийн Жаргалан сумын “ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ” зорилтот ажлын үйл явц

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

“Тогтвортой амьжиргаа-3” төслөөс 6 сая, Орон нутгийн төсвөөс 1 сая 200.000 төгрөгөөр санхүүжсэн. Нийт 7.200.000 төгрөгийн төсөв зарцуулсан.

ХҮРСЭН ҮР ДҮН

- Сургалт, 320 иргэнд ОНХС-ийн хөрөнгөөр хийж хэрэгжүүлж буй ажилд, хяналт, тавих талаар, хяналтын бүлгийн журам хэлэлцүүлсэн сургалт зохион байгуулсан. АЧББ-ын багш нараар хичээл заалгаж, 13 хяналтын бүлэг байгуулж, аймаг сумын түвшинд хийж хэрэгжүүлж буй ажилд хяналт хийлгэн ажиллуулж байна.
- Мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулж ажиллах сургалтад оролцсон иргэдэд гарын авлага өгч мөн, аймгийн хоёр сонины газар, хоёр телевизтэй гэрээ байгуулан үйл ажиллагаагаа цаг тухайд нь сурталчилж, МОНЦАМА, сошиал мэдээ, ТВ-9 телевизээр мэдээ мэдээлэл гаргасан.
- Иргэд маш идэвхтэй болсон,
- Хийж хэрэгжүүлж буй ажлын талаар иргэдэд мэдээлэх самбарыг нь компаниуд ажиллуулсан,
- Иргэний хяналтын бүлэг ажилладаг гэсэн мэдээ мэдээлэлтэй болсон,
- Хугацаандаа хийж гүйцэтгэхгүй байгаа ажил алданги тооцох тухай дүгнэлтүүд гарсан,
- Ямар компани хийж хэрэгжүүлж буй талаар олон нийтэд мэдэгдсэн.



ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Тус ажлыг хийж гүйцэтгэхэд төсөв санхүүгийн асуудлыг шийдвэрлэхэд бэрхшээл үүсэж байсан.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

Сургалт, хэлэлцүүлгийг явуулснаар иргэд бид бүхэн цаашид ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажилд хэрхэн яаж оролцож болох, хийгдэж байгаа ажлуудад хяналт тавих эрхтэй гэдгийг ойлгож авсан маань энэ удаагийн сургалтыг зөв оновчтой байж чадсан нь харагдаж байна.

Энэхүү сургалтад хамрагдсанаар бидний бүхний санал санаачилга идэвх оролцоотойгоор энэ бүх ажил зөв хийгдэж чадна гэсэн боломжийг харж чадлаа. Цаашид бид бүхэн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй бараа, ажил үйлчилгээнд гэрээний дагуу хяналт тавих, шаардах, ажлыг нь шахаж зөв хийлгэх хүлээж авахад хүртэл бидний оролцоо чухал үүрэгтэй гэдгийг олж харлаа. Та бүхэн маань бас цаашид сумаас баталж хэрэгжүүлж буй ажлаа ард иргэдийн саналаар буюу эрэмбэлэгдэж гарж ирсэн бидний ажлыг хийж хэрэгжүүлдэг болон гэж найдаж байна.

Ховд аймгийн Жаргалант сумын иргэний сэтгэгдлээс...

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

1. Иргэд, төрийн албан хаагчид ОНХС-ийн талаар мэдээлэлтэй болсон.
2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулахыг иргэд шаардах болсон.
3. Иргэд ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт тавихын зэрэгцээ цаашид үйл ажиллагааг сайжруулахад саналаа тусгасан.



1. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

**“ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАН ЧАДАВХЫГ
БЭХЖҮҮЛСЭН НЬ”****САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ**

Х.ДАВААСҮРЭН, Хөвсгөл Аймгийн Цагаан-Уул сумын ИТХ-ын дарга.

Бага ангийн багш мэргэжилтэй. Боловсролын салбарт тасралтгүй 16 жил ажилласан. 2016 оноос сумын ИТХ-ын даргаар ажиллаж байна.

Холбоо барих утас: 99384072

АГУУЛГА

БИНХ-д эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлснээр тэдний өмнө тулгамдаж байсан асуудлыг шийдвэрлэх боломж бүрдсэн.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Сүүлийн жилд Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын хэмжээнд зохион байгуулагдсан ИНХ-ын оролцогчдыг хүйсээр нь харьцуулбал эрэгтэйчүүд 75 хувь эмэгтэйчүүд 25 хувийг эзэлж байна. БИНХ-д ирсэн бүрэлдэхүүнийг дийлэнхийг өрхийн тэргүүлэгчид эзэлж, тэдний гаргасан шийдвэр МАА-н эргэн тойронд өрнөж малын хашаа, булгийн эх хашаалах, хадлангийн талбай хамгаалах гэх мэт иргэдийн ухамсарт үйл ажиллагаанаас шалтгаалах аар саархан асуудалд хөрөнгө зарцуулж, тэр нь эргээд ашиглалт хамгаалалтын талын үйл ажиллагаатай хамаарагдах шийдвэрүүд хэлэлцэгдэж шийдвэр гаргасан байдаг. Бид эмэгтэйчүүдээ багийн хурал зөвлөгөөнд түлхүү оролцуулбал өрх гэр бүлийн хөгжил, охид эмэгтэйчүүдийн өмнө тулгамдсан асуудлууд зохих хэмжээнд яригдах нь тодорхой харагддаг ба багийн ИНХ-ын шийдвэрт эмэгтэйчүүдийн санал тусгаагдах боломжтой болох юм.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын эмэгтэйчүүдийг хамруулав.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2018.07.01-ээс 2018.12.01-ны хооронд сургалтын үйл ажиллагааг зохион байгуулсан

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

Цагаан-Уул сумын хувьд 1571 өрхөөс баг, байгууллага, гудамж, хорооллын төлөөлөл болсон 70 эмэгтэйг сонгон авч “Аравтын зохион байгуулагч”-д болж хурлын зарыг хүргүүлдэг болсон. Мөн БИНХ-ын шийдвэрт хэрхэн оролцох, бусдыг хэрхэн манлайлж идэвхжүүлэх, сургаач багш нарыг чадавхжуулан ажиллуулах, эмэгтэйчүүдэд илүү ойртож ажиллах замаар Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр боловсруулан гаргах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх сургалтуудыг зохион байгууллаа.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- Сумын эмэгтэйчүүдээс санал асуулга авч, тэдэнд тулгамдаж буй асуудал болоод цаашид хэрхэн эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх талаар судалсан,



- Эмэгтэйчүүдэд манлайллын сургалт зохион байгуулсан,
- Сумын эмэгтэйчүүдийн дунд тэдний санал бодлыг сонсох бүлгийн ярилцлага зохион байгуулсан,
- БИНХ хуралдуулж “Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөрт” санал авах ажлыг зохион байгуулсан,
- Багуудаас гарсан саналуудыг нэгтгэн, хэлэлцүүлэг зохион байгуулсан,
- Эмэгтэйчүүдийн санал санаачилгаар хийгдэх ажлуудын төлөвлөгөөг боловсруулсан,
- Эмэгтэйчүүдийн зөвлөгөөн зохион байгуулсан,
- “Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр”-ийг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулсан,
- Сургалт зохион байгуулахын тулд сургалтын хөтөлбөрөө боловсруулан сургалтыг зохион байгуулах хүний нөөцөө бүрдүүлсэн.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Сумын ИТХ-ын байгууллага нь 2018 оны 6 дүгээр сард Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслөөс зарласан ИТХ-ын үйл ажиллагааг дэмжих тэтгэлэгт “БИНХ-д эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь” төслийг хэрэгжүүлэхээр шалгарч 3.0 сая төгрөгийн санхүүжилтийг авч, орон нутагт хэрэгжихээр батлагдсан “Багийн иргэд нийтийн хуралд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь” төслийн ажлыг тэтгэлэг олгогчтой байгуулсан гэрээний дагуу хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг төлөвлөгдсөн хугацаанд нь зохион байгуулж, төслийн санхүүжилтийг зардлын зүйл, зориулалтын дагуу зарцуулсан.

ХҮРСЭН ҮР ДҮН

Төслийг хэрэгжүүлснээр орон нутагт НӨУБ-ын чадавхыг бэхжүүлэх талаар дараах үр дүнд хүрч байна. Үүнд:

- Багийн ИНХ болон эмэгтэйчүүдийн дунд зохиогдох төрөл бүрийн үйл ажиллагааны төр захиргааны болон бусад байгууллагаас зохион байгуулах ажлын зар мэдээг Аравтын бүлгийн зохион байгуулагчдаараа дамжуулах гэр бүлд хүргэх нөхцөл бүрдсэн,
- БИНХ-ын ирц сайжирч хурлаар хэлэлцэх асуудал товч тодорхой оновчтой болж хурлын шийдвэр иргэн бүрд хүрэх нөхцөл бүрдсэн,
- Мэдээллийн ил тод байдал, иргэдийн мэдээлэл авах боломж нэмэгдсэн,
- БИНХ-аас эмэгтэйчүүдийн өмнө тулгамдсан асуудлаар шийдвэр гаргуулах ОНХС-ийн хөрөнгөөр шийдвэрлэж болох ажлуудаа эрэмбэлүүлэхэд олонхын санал авах нөхцөл бүрдсэн,
- Эмэгтэйчүүдийн санал хүсэлтийг үндэслэн орон нутгийн хөгжилд тодорхой хувь нэмэр болох эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөрийг гаргаж албажуулан хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн,
- Орон нутгийн хөгжил, дэвшил, нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд оролцох эмэгтэйчүүдийн оролцоо, санал санаачилга идэвхэжсэн,
- Сум орон нутгийн нийгмийн салбар байгууллагуудын үйл ажиллагаанд эмэгтэйчүүд хяналт үнэлгээ хийх, ИНХ-аараа хэлэлцэн шийдвэрлэх талаар мэдлэгтэй болсон.

Сумын иргэдэд бий болсон ашиг тус:



- Сумын ИТХ, БИНХ-ын эрх үүргийг мэдэж , хурлаар хэлэлцэх асуудал иргэн бүрд нээлттэй гарах шийдвэр нь амьдрал ахуйд нөлөөлөх ёстойг мэдэж авсан. Мөн иргэд хамтарч ажиллавал аливаа асуудлыг шийдвэрлэх боломжтойг мэдэж авсан,
- 2019 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын зардлаар эмэгтэйчүүдийн хөгжлийн ордны зураг төсөвтэй болсон,
- Мөн 2019 оны 6 дугаар сард "Эмэгтэйчүүд манлайлал" чуулганд оролцож буй 400 эмэгтэйчүүдэд Багийн иргэд нийтийн хуралд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь төслийн тайлан туршлагын номд тайлангаа хүргүүлсэн.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Хөдөөгийн багуудаар 45-60 км явж зуслангийн газрын хэсэгт эмэгтэйчүүдээ цуглуулан сургалт явуулахад цаг уурын байдлаас болж хугацаа өөрчлөгдөх , бензин шатахууны зардал хүрэлцэхгүй байх зэрэг хүндрэл гарч байлаа. Эмэгтэйчүүдийн сэтгэл санааг эмзэглүүлсэн гол тулгамдсан асуудал хогны асуудал байсан тул хог цэвэрлэгээний ажил зохион байгуулах, хогийг хэрхэн ангилан ялгаж хаях талаар гарын авлага тараах материал бэлтгэж өрх бүрд хүргэх шаардлагатай болсон нь цаг хугацаа, төсөв төлөвлөснөөс хэтрэхэд хүргэсэн.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

Эмэгтэйчүүд төлөөллийн байгууллагын тухай мэдээлэлтэй болж түүнийхээ үр дүнд багийн нийтийн хурлын ирц нэмэгдэж байна. Энэ нь эмэгтэйчүүд төрд дуу хоолойгоо хүргэх боломжийг ч нэмэгдүүлж байна. Эмэгтэйчүүд бид араг арваараа зохион байгуулалтад орж сургалт хөтөлбөрт хамрагдаж хэрхэн бусад эмэгтэйчүүдийн дуу хоолой болох, хэрхэн хамтдаа хөгжиж болох талаар ӨМӨЗО, Улаанбаатар хотод туршлага судалж ирсэн.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын иргэн Б.Амаржаргал

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС


Багийн төлөөлөл бүхий эмэгтэйчүүд "Аравтын бүлэг"-ийн зохион байгуулалтад орсноор иргэд мэдээллийг хурдан, шуурхай, баттай эх сурвалжаас авах болсон.

БИНХ-ийн ирц сайжирснаар иргэд төлөөллийн байгууллагын үйл ажиллагаанд санал, бодлоо илэрхийлэх байдал нэмэгдсэн.

Эмэгтэйчүүд сум орон нутгийн хөгжлийн асуудалд хувь нэмрээ оруулах болсон нь хөгжлийн түүчээ залууст үлгэрлэх туршлага болж байна.

Орон нутгийн хувьд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх замаар төлөөллийн байгууллага үйл ажиллагаагаа иргэдэд хүргэсэн.

Хавсралт 1. Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай 38 дугаар тогтоол



Хавсралт 2. Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн
34 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

"Өөрчлөлтийг өөрөөсөө эхлүүлье"

№	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа	Хөрөнгийн үүсвэр		Хариуцах тушаалтан албан	Хүрэх үр дүн
			Орон нутгийн төсөв	Бусад орлогоос		
1. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, СОЁЛ СПОРТЫН ТАЛГААР						
1.1	Эмэгтэйчүүдийн дунд байгууллага баг бүр дээр "Эрүүл мэнд-Гэр бүл" сургалтыг зохион байгуулж, эмийн зохистой хэрэглээ, элдэв өвчний эхлэл архидалт, тамхидалтын хор холбогдолын талаар зөвлөмж гарган өрх бүрт хүргэж ажиллана	2019 онд	500,0		Баг байгууллагын дарга, зохион байгуулагч эмэгтэйчүүд	Өвчлөл буурч, эмийг эмчийн жороор олгодог хэрэглэдэг болох, архи тамхийг зохистой хэрэглэж хэвшүүлнэ. Гэр бүлээрээ нийлж архидах байдлыг бууруулах
1.2	Нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болоод байгаа Хорт хавдраас урьдчилан сэргийлэх мэдээлэл сургалтыг зохион байгуулж Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд өрх гэр бүлээрээ хамрагдаж байх ажлыг зохион байгуулна	2019 онд			ЗДТГазар, ЭМБайгууллага, эмэгтэйчүүдийн зөвлөл, зохион байгуулагч эмэгтэйчүүд	Өрх гэр бүлдээ эрүүл энхийн аз жаргалыг авчирна. Эрт илрүүлж эмчилгээний үр дүн сайжирна.
1.3	"Эрүүл байх эрхэм зорилго" сэдэвт аяныг жил бүр эмэгтэйчүүдийн дунд зохион байгуулж гарсан санал санаачилгын дагуу хяналт үнэлгээ хийж зөвлөмж гарган хэрэгжүүлнэ	2019-2024 он хүртэл		500,0	ИТХ, Эмэгтэйчүүдийн зөвлөл	Эрүүл мэндээ хамгаалах, тогтмолжсон дэглэмтэй болж өвчнөөс урьдчилан сэргийлэх ойлголт, эрүүл аж төрөх ёсыг эзэмшинэ.
1.4	Эмэгтэйчүүдийн зөвлөлийн зохион байгуулагч 70 эмэгтэйг Иргэний	2019-2024 он	500,0		ИТХ, эмэгтэйчүүдийн зөвлөл	Эмэгтэйчүүдийн днд явуулах үйл
	нийгмийн байгууллагын "Мөнлайлал"-ын сургалтанд хамруулж зохион байгуулах үр чадварыг дээшлүүлж чадавжуулна					ажиллагааны үр дүн дээшилнэ. 10-тэн системд шилжих арга арга ажиллагаа тогтмолжсоно.
1.5	Эмэгтэйчүүдийг ахмад дунд, залуу үеийн гэсэн хэсэгчилсэн сургалтанд хамруулж эмэгтэйчүүдийн түүхэн замнал уламжлалт зан заншил, эзэн Чангис хааны алтан сургаалийг дэлгэрүүлнэ.	2020-2021		500,0	Эмэгтэйчүүдийн зөвлөл, БЗД нар, ахмадын хороо	2012 онд одонт ээжүүдийн чуулганаас гарсан хөгжлийн хөтөлбөрийг судалж зан, ёс зүйн суртахууны байдал дээшилнэ.
1.6	Бичиг үсэг тайлагдсан эмэгтэйчүүдээ сургалтанд хамруулж эрдэм боловсролыг дээшлүүлнэ	2019-2020			ЕБС, Эмэгтэйчүүдийн зөвлөл	Бичиг үсэг үл мэдэгчгүй болно
1.7	Эх хэл бичиг дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2019-2024			ЕБС, Эмэгтэйчүүдийн зөвлөл, ЗДТГ	2025 он гэхэд төрийн бичиг хэрэг Монгол бичгээр явагдахад Эмэгтэйчүүдийн нэлээд хэсэг нь бэлтгэгдсэн монгол бичиг үсэг сурсан байна.
1.8	Хүүхэд, Залуучуудын хүмүүжил, харьцаа, хандлагын элдэв гажуудлыг анхаарч, зөв дадал заншилтай болгох буруу зуршилд автахаас урьдчилан сэргийлэх хүмүүжлийн ажлуудыг зохион байгуулна	2019-2024 хүртэл			Байгууллага бүрийн нийгмийн ажилтнуудтай хамтарч ажиллана	Гэр бүл дотор амьд харьцаатай болох цахим хэрэглээг зохистой байлгана. Зөв сайхан хүмүүжилтэй болох Орон нутгийн оролцоо нэмэгдэнэ.
1.9	Уламжлалт баяр, тэмдэглэлт үйл явдлуудыг нийтийн хэмжээнд зохион байгуулж эмэгтэйчүүдийн уулзалт-үдэшлэг урлаг спортын тэмцээнүүдийг сонирхолтой хэлбэрээр явуулж, эмэгтэйчүүдээ алдаршуулах ажлуудыг судалгаанд тулгуурлан явуулна	2019-2024	400,0	1000,0	ИТХ, ЗДТГ, Соёлын төв, Эмэгтэйчүүдийн зөвлөл	ОУ-ын эмэгтэйчүүдийн баяр, Гэр бүлийн баяр, зуны аялал, туршлага солилцох ажлууд тогтмол чанартай Хөдөлмөрийг үнэлэх шагналд тодотгоо ажил бодитой болгоно
2. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ						

2. Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал “ҮЕ ҮЕИЙН МАНЛАЙЛАГЧДААС СУРАЛЦСАН НЬ”

САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ



С.ТҮМЭНБАЯР, Дорноговь аймгийн ИТХ-ын дарга. Төмөр Замын техникум болон ОХУ-ын Эрхүү хотын Төмөр замын дээд сургууль, 2007-2009 онд Удирдлагын академийг Бизнесийн удирдлагын менежер, Монгол Улсын Зөвлөх инженер. 2004-2008, 2008-2012, 2012-2016, 2016-2020 онуудад нийт 4 удаа сонгогдон 16 жил төлөөлөгчөөр ажиллаж байна.

Холбоо барих утас: 99993699, **Цахим хаяг:** S.tumenbayar@yahoo.com

АГУУЛГА

Дорноговь аймгийн НӨУБ-д 1992-2019 онуудад ажиллаж байсан болон байгаа үе үеийн дарга, нарийн бичгийн дарга нарын “Бидний үе” уулзалт, зөвлөгөөнийг улсын хэмжээнд анхдагчаар зохион байгууллаа.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

НӨУБ-ын 1992 оноос хойших нэгдсэн түүхэн архив, мэдээлэл байхгүй бөгөөд хурлын байгууллагуудад ажиллаж байсан хүмүүсийг нэг дор уулзуулж байсан ажил огт хийгдэж байгаагүй. НӨУБ-ыг иргэд олон нийтэд сурталчлах, үнэ цэнэ, түүхийг ойлгуулах томоохон ажил хийх шаардлагатай болсон. Үе үеийн удирдагч, манлайлагчдын туршлагаас суралцах шаардлагатай болсон.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Дорноговь аймгийн ИТХ-ын үе үеийн дарга, нарийн бичгийн дарга нар болон одоо ажиллаж буй мэргэжилтэн, төлөөлөгчид .

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

Бэлтгэл ажлын төлөвлөгөөг 2019 оны 09 дүгээр сард гарган тус төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлыг сайтар хангаж 2019 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Дорноговь аймгийн Сайншанд хотод зохион байгуулав

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

Үе үеийн удирдлагууд, нарийн бичгийн дарга нарыг урин уулзалт зохион байгуулснаар харилцан бие биеэсээ суралцах боломжийг олгосон. Мөн одоогийн НӨУБ-ийн үйл ажиллагаа, баримтлах зарчимд саналаа тусгаснаар цаашид зөв чиглэлд үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломж бүрдсэн.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- Нийт 14 сумдаас судалгааг авч нэгтгэн, уулзалт, зөвлөгөөнд оролцогчдын ирцийг гарган, бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулан, төлөвлөгөөний дагуу ажилласан,
- Хамгийн Хамгийн номинаци гарган тус номинацийн дагуу алдаршуулах үйл ажиллагааг зохион байгуулсан /Хамгийн олон жил нутгийн өөрөө удирдах байгууллагад ажиллаж байсан, хамгийн ахмад, хамгийн залуу насандаа хурлын дарга, нарийн бичгийн даргаар ажиллаж байсан, хамгийн олон жил аймаг, суманд төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байсан гэх мэт/,



- Монголын нутгийн удирдлагын холбооны шагнал, зөвлөх мэргэжилтний үнэмлэх, аймгийн ИТХ-ын өргөмжлөлөөр оролцогчдоос шагнаж урамшуулав,
- Нийт оролцогчдод аймгийн ИТХ-ын дурсгалын тэмдэг, үнэмлэхийг зориулан гаргаж, гардуулсан,
- Үе үеийн төлөөлөгчид, удирдлагуудыг Аймгийн бүтээн байгуулалтын ажлуудтай танилцуулсан,
- Оролцогчдын дурсамж яриа болон үйл ажиллагааг TV-8 болон орон нутгийн телевиз, мэдээллийн бусад хэрэгслээр мэдээлсэн,
- Энэхүү арга хэмжээнд зориулан телевизийн нэвтрүүлгийг тусгайлан бэлтгэн олон нийтэд түгээсэн,
- Аймаг, сумд, нийтээр нь дурсгалын зураг авхуулж дурсгал болон гарын бэлэгтэй өгсөн.



Дорноговь аймгийн ИТХ-ын “Бидний үе” уулзалтын үеэр

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Аймгийн ИТХТ-ийн 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 76 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Аймгийн ИТХ-аас зохион байгуулах уулзалт, зөвлөгөөнд оролцох үе үеийн дарга, нарийн бичгийн дарга нарын уулзалтын төсвийг баталсан. Нийт төсөв 17380000 /Авран долоон сая гурван зуун наян мянга/ мянган төгрөг.

ХҮРСЭН ҮР ДҮН

- НӨУБ-ын үе үеийн дарга, нарийн бичгийн дарга нарын үнэтэй сургаал, зөвлөмжийг залуу үеийн төлөөллүүдэд хүргэх, тэдгээр удирдлагуудыг хүндэтгэн хүлээн авах “Бидний үе” уулзалт, зөвлөгөөнийг амжилттай зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 1992-2019 онуудад 14 сумын НӨУБ-д ажиллаж байсан болон байгаа 120 гаруй дарга нар оролцов. Энэхүү уулзалт, зөвлөгөөн нь аймагт төдийгүй Монгол Улсдаа анхдагч боллоо хэмээн оролцогчид онцолж, сэтгэгдэл өндөр байсан юм.

- Аймаг, сумдын ИТХ-ын тухай түүхэн номыг бүтээх, үйл ажиллагаагаа сурталчлан иргэд, олон нийтэд таниулах, НӨУБ-ыг төлөвшүүлэн бэхжүүлэх талаар үе үеийнхний үнэтэй санал бодлыг хүлээн авах, онцлог хүмүүсийг алдаршуулах, НӨУБ-ын үнэ цэнийг нэмэгдүүлэх, түүхээ эргэн санаж алдаа оноогоо дүгнэж, цаашид илүү сайжруулан ажиллах санал санаачилгыг өрнүүлэхэд уулзалт, зөвлөгөөн нь үр дүнтэй ажил болж өндөрлөлөө. НӨУБ-д ажиллаж байсан ахмад удирдлагуудыг хүндэтгэсэн нь томоохон ач холбогдолтой арга хэмжээний нэг болсон.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

НӨУБ-ын үе үеийн /1992-2019 он/ дарга, нарийн бичгийн дарга нарт уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах тухай зарыг түгээхэд зарим хүмүүсийн холбоо барих шинэчилсэн мэдээлэл байхгүй байх, өөр аймагт шилжин суурьшсан, зарим нь эрүүл мэндийн шалтгааны улмаас тус арга хэмжээнд оролцох боломжгүй, уулзалтын агуулга, ач холбогдлыг ойлгохгүй байх гэх мэт асуудлуудтай тулгарч байсан хэдий ч нийт 120 гаруй аймаг, сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарыг нэг дор хамруулж чадсан арга хэмжээ болж өндөрлөсөн юм.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

Дорноговь аймгийн ИТХ-аас зохион байгуулсан НӨУБ-д ажиллаж байсан үе үеийн ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, ажилтнуудын “Бидний үе” уулзалт, арга хэмжээ нь цаг үеэ олсон маш чухал ажил болсныг тэмдэглэн хэлэхэд таатай байна. Монгол улсад шинээр үүсэн байгуулагдаад эдүгээ 30 шахам жил болж байгаа НӨУБ-д анх ажиллаж байсан ахмад ажилтнууд энэхүү дурсамж уулзалтад оролцож өөрийн ажиллаж байсан цаг үе, бүхнийг шинээр эхэлсэн дурсамжаа сэргээн, энэ байгууллагыг өдий зэрэгт хүргэн хөгжүүлсэн арвин баялаг туршлагаа хуваалцсан сайхан арга хэмжээ боллоо.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ИТХ-ын дарга асан Д.Баатар

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Энэ цаг үед болон өмнөх жилүүдэд ажиллаж байсан төлөөллийн байгууллагын үе үеийн дарга нар, албан хаагчид ажлын туршлагаа солилцсоноор үйл ажиллагааг сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулсан.

Өмнөх жилүүдэд төлөөллийн байгууллагад ажиллаж байсан туршлагатай удирдлага, албан хаагчдаас ажлын туршлагын хувьд болон орон нутагт төлөөллийн байгууллагын оролцоотойгоор хийх боломжтой үйл ажиллагааны шинэлэг санааг хуваалцсан.

Хавсралт 1. Уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах тухай 76 дугаар тогтоол

ДОРНОГОВЬ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 76

Дорноговь аймаг, Сайншанд сум

Уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9, 25 дугаар зүйлийн 25.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймгийн ИТХ, Тэргүүлэгчид ажлын албаны 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 6.10 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 1992 оноос хойшхи үе үеийн дарга, нарийн бичгийн дарга нарын “Бидний үс” уулзалт, зөвлөгөөнийг 2019 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Сайншанд хотод зохион байгуулсугай.

2. Уулзалт, зөвлөгөөний хөтөлбөрийг 1 дүгээр, зардлын төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дээрх зардлын 17380000 /Арван долоон сая гурван зуун наян мянган/ төгрөгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны Хичээл үйлдвэрлэлийн болон Мэдээлэл сурталчилгааны зардлаас гарган санхүүжүүлэхийг төсвийн шууд захирагч /Н.Хонгорзул/, нягтлан бодогч /Б.Наранцацрал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.ТҮМЭНБАЯР

443190228

Хавсралт 2. Аймгийн ИТХ-аас зохион байгуулах уулзалт, зөвлөгөөнд оролцох хурлын төсөв

Аймгийн ИТХ-ын Төргүүлэгчдийн
2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн
19 дугаар тогтоолын 4 дугаар хавсралт

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛААС ЗОХИОН БАЙГУУЛАХ
УУЛЗАЛТ, ЗӨВӨЛГӨӨНД ОРОЛЦОХ ХУРЛЫН ҮЕ ҮЕИЙН ДАРГА, НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА НАРЫН УУЛЗАЛТЫН ТӨСӨВ**

№	Зардлын нэр	хэмжих нэгж	тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Тайлбар
1	1 р хоол	ш	140	7900	1106000	
2	2 р хоол	ш	140	10900	1526000	
3	Цай	ш	140	600	84000	
Дүн					2716000	
1	2 р хоол	ш	140	23900	3346000	
2	салат	ш	140	7900	1106000	
3	Ундаа	ш	140	3000	420000	
4	Ус	ш	140	1500	210000	
5	Десерт	ш	140	6400	896000	
6	Цай	ш	140	1000	140000	
Дүн					6118000	
1	Чихэр	кг	8,4	15000	126000	
2	Жимс	багц	1	695200	695200	
3	Зөвлөгөөний ус	ш	140	320	44800	
Дүн					866000	
Бусад						
1	Баннер	м	1	40000	40000	
2	Сугалаа	ш	5	105000	525000	
3	Тэмдэг	ш	140	4000	560000	
4	Урилга	ш	140	1100	154000	
5	Түлхүүрийн оосор	ш	140	1400	196000	
6	Жааз, зураг угаалгах	ш	15	25000	375000	
7	Үнэмлэхний гадар, үнэмлэх	ш	140	1300	182000	
8	Номинацийн шагнал	ш	16	30000	480000	
9	Номинацийн дагалдах багламж	ш	16	10000	160000	
10	Шатахуун /Автобус-4/	л	1	108000	108000	
11	Гарын бэлэг	багц	140	35000	4900000	
Дүн					7680000	
Нийт дүн					17380000	

3. Увс аймгийн Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

“ЭМЭГТЭЙ ТӨЛӨӨЛӨГЧИД СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГ СЭРГЭЭСЭН НЬ”**САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ**

Ц.ДАРИЙМАА нь Увс аймгийн Улаангом сумын ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч. Улаангом сумын Улсын Тэргүүний 2-р сургуульд МХУЗ-ын багшаар ажилладаг. Хүмүүнлэгийн ухааны их сургуулийг Хэл шинжлэлийн магистр зэрэгтэй.

Холбоо барих утас: 99455512,

Цахим хаяг: uq.khural@gmail.com



С.БУЛГАМАА, Увс аймгийн Улаангом сумын ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч. “Сэргээлэн тархи” мэдрэлийн эмнэлгийн дарга, АУ-ны магистр, Клиникийн профессор, мэдрэлийн эмч.

Холбоо барих утас: 99459181,

Цахим хаяг: uq.khural@gmail.com

АГУУЛГА

Увс аймгийн Улаангом сумын эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоог нэмэгдүүлэх замаар орон нутгийн СХС-ийн зээлийн үйл ажиллагаанд хяналт тавьсан.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

СХС-ийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй учраас СХС-ийн ямар ч эргэлтийн хөрөнгөгүй болсон. НӨУБ-ын үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоо, манлайлал бага, иргэдэд хүрч ажиллах нь хангалтгүй байсан

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Увс аймгийн Улаангом сумын ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчид

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2018-2019 онд хэрэгжүүлсэн.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

Улаангом сумын ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчид, багийн ИНХ-ын дарга, ИТХ-ын ажлын албаны хамтарсан ажлын хэсэг Сумын хөгжлийн сангийн гүйцэтгэл, ОНХС-ийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнд хяналт шалгалт хийсэн.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаас ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчид, багийн ИНХ-ын дарга, ИТХ-ын ажлын албаны хамтарсан ажлын хэсэг байгуулах шийдвэр гаргасан.
- Сумын эмэгтэй төлөөлөгчид СХС-ийн гүйцэтгэл, зээлийн эргэн төлөлтөд анхаарал хандуулах санаачилга гаргаж СХС-ийн гүйцэтгэл, ОНХС-ийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнд хяналт шалгалт хийсэн.
- СХС-аас авсан зээлдэгч нарын үйл ажиллагаатай танилцаж зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх, ажлын байрыг нэмэгдүүлж байгаа эсэхийг нягтлан шалгаж

хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх арга хэмжээ авах зорилгоор зээлдэгч нартай очиж



Увс аймгийн Улаангом сумын ИТХ-ын төлөөлөгчид сум хөгжүүлэх сангийн эргэн төлөгдөөгүй зээлийг татан төвлөрүүлэх үйл явц.

уулзаж нөхцөл байдалтай танилцсан.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

ОХУ-ын Курагино районы ИТХ болон хотын захиргаатай хамтарч ажиллах уулзалтад эмэгтэй гишүүдийн оролцоог нэмэгдүүлж дэмжиж ажиллана гэсэн журмын дагуу ИТХ-ын зардлаас шийдвэрлэсэн. Улаанбаатар хотод болсон эмэгтэй төлөөлөгчдийн туршлага солилцох уулзалтад зохион байгуулагч байгууллага санхүүжилтийг олгосон.

ХҮРСЭН ҮР ДҮН

- Хяналт шалгалтын үр дүнд 2018 оны 11 сард СХС-ийн дансанд 130 сая төгрөгийг татан төвлөрүүлж ОНХС-аар хийгдсэн ажлын явц, гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөн тусалж ажиллалаа.
- 2018 онд “Сайн туршлага” ажлын хүрээнд МОНФЕМНЕТ сайн туршлага хуримтлуулах сургалтад эмэгтэй төлөөлөгчид хамрагдаж 2019 онд “МОНФЕМНЕТ” үндэсний сүлжээнээс эрхлэн гаргасан “ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдийн сайн туршлага”-ууд номд төлөөлөгч Ц.Дариймаа, С.Булгамаа нарын сайн туршлага нийтлэгдсэн.
- ОХУ-ын Курагино районы ИТХ болон хотын захиргаатай хамтарч ажиллахад Улаангом сумын ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгчид эдийн засгийн форумд амжилттай оролцож хамтын ажиллагаагаа өргөжүүлэх цаашид хамтран ажиллах гэрээ хэлэлцээр байгууллаа.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

СХС-аас зээл авсан иргэнтэй уулзаад, ярилцаад явахад эргэн төлөх боломжгүй нөхцөл байдлууд үүсэж байсан.

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

ОНХС-ийн талаар иргэд мэдлэг, мэдээлэлтэй болж төлөөллийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих байдлаар оролцох болсон.

Сумын иргэдийн оролцоотойгоор ОНХС-ийн үйл ажиллагааг идэвхжүүлж, гацалтад орсон байсан 130 сая төгрөгийг эргэн төлүүлсэн байна.

Иргэдийн оролцоотойгоор эргэн төлөлтөд орсон мөнгөн хөрөнгийг сумын ОНХС-ийн эргэлтэд оруулах боломжтой болсон.

Олон нийтийн оролцоо, тэдний санал ИТХ-ын үйл ажиллагаанд бодитой хэрэглэх болсон.

4. Дундговь аймгийн Адаацаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

“ИРГЭДИЙН ХЯНАЛТ БА ХӨГЖИЛ”**САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ**

Г.УРАНБИЛЭГ нь Дундговь аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга. Хүнс үйлдвэрлэлийн технологи, эрүүл ахуйч, Төрийн захиргаа удирдлага мэргэжилтэй. 2008-2009 онд Адаацаг сумын дунд сургуулийн Эрүүл ахуйч, 2009-2017 оны 02 сарын 02 хүртэл Дундговь аймгийн Адаацаг сум ЗДТГ 1-р багийн Засаг дарга, 2017 оны ИТХ-ын нарийн бичгийн даргаар одоог хүртэл ажиллаж байна.

Холбоо барих утас: 94448081 Цахим хаяг: u.bileg1985@gmail.com

АГУУЛГА

СХС-ийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоотой, хяналт тавих орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулсан.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

СХС-ийн зээлтэй иргэд хугацаандаа зээлээ төлөхгүй, сумын хугацаа хэтэрсэн хариуцлагагүй зээлдэгч нарын тоо ихэссэн, СХС-ийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн иргэний төлөөллийг БИНХ-аас иргэдийн дундаас сонгоогүй, сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөлийн барьж ажиллах ямар нэгэн дүрэм журам байхгүй зэрэг тулгамдсан асуудлууд байсан.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Адаацаг сумын иргэд болон ИТХ-ын төлөөлөгчид, СХС-ийн зээл авсан иргэд.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2018-2019 онд хэрэгжүүлсэн.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

СХС-ийн үйл ажиллагаанд, иргэдийн оролцоотой хяналт тавих орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах нь төслийг хэрэгжүүлэх санааг олж, Монгол Улсын Их Хурал, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлсэн “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг хэрэгжүүлэх нь” төсөлд хамрагдаж тулгамдсан асуудлаа шийдвэрлэсэн.

Сумын СХС-ийн үйл ажиллагаанд, иргэдийн оролцоотой, хяналт тавих орон тооны бус зөвлөл өмнө нь 2017 оны 01 сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолын хавсралтаар дараах бүрэлдэхүүнтэй байгуулагдсан болно.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- БИНХ-ыг зохион байгуулж, төслийн талаар танилцуулж сургалт зохион байгуулан багийн иргэний төлөөллийг сонгосон,



- Сумын СХС-ийн, хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар шинээр байгуулсан,
- Хяналт шалгалтыг зохион байгуулж, цаашид хамтарч ажиллах төслийн багийн бүрэлдэхүүн болон, ИТХ-ын Төлөөлөгч, иргэний төлөөлөлд сургалт зохион байгуулсан,
- СХС-ийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоотой хяналт, шалгалт явуулах удирдан зохион байгуулах баг бүрдүүлсэн, БИНХ-уудаар төслийн явцын талаар танилцуулж, орон тооны бус зөвлөлүүдийн бүрэлдэхүүнийг танилцуулсан,
- Төсөл хэрэгжүүлэх багийн бүрэлдэхүүн орон тооны бус зөвлөлийн хяналт шалгалт зохион байгуулах дүрэм журам боловсруулан гаргасан.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Адаацаг сумын ИТХ-аас “СХС-ийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоотой хяналт тавих орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах нь” төсөлд 3 сая төгрөгийн санхүүжилт гаргаж өгсөн.

ХҮРСЭН ҮР ДҮН

- СХС-ийн үйл ажиллагаанд, иргэдийн оролцоотой хяналт тавих орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах нь төслийг хэрэгжүүлэх санааг олж, Монгол Улсын Их Хурал, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлсэн “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг хэрэгжүүлэх нь” төсөлд хамрагдаж тулгамдсан асуудлаа шийдвэрлэсэн.
- БИНХ-аар төсөл хэрэгжүүлэх багийн гишүүн ИТХ-ын нарийн бичгийн дарга Г.Уранбилэг СХС-ийн өнөөгийн байдал, төсөл хэрэгжүүлэх болсон тухай танилцуулж, СХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын талаар сургалт зохион байгуулж, гарын авлага материал бэлтгэн хүргэсэн бөгөөд сургалтад 1-р багийн 58, 2-р багийн 73, 3-р багийн 50, 4-р багийн 57, 5-р багийн 74, нийт 312 иргэн хамрагдсан.
- БИНХ-ыг зохион байгуулж СХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах хяналт тавих журмын талаар сургалт зохион байгуулж, гарын авлага материал бэлтгэж хүргэсэн бөгөөд цаашид иргэдээ төлөөлж ажиллах иргэний төлөөллийг сонгосон.
- СХС-ийн зээлтэй иргэдэд сумын жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн, ИТХ-ын нарийн бичгийн дарга сургалт зохион байгуулсан. Сургалтад иргэдийг бүрэн хамруулахаар урилга хүргүүлсэн.
- СХС-ийн зээлд хяналт тавих орон тооны бус зөвлөлийн цаашид ажиллах нөхцөл боломжийг бий болгосон.
- СХС-ийн хугацаа хэтэрсэн хариуцлагагүй зээлдэгч нарын тоо багассан, зээлийн хугацаа нь дуусаад зээлээ төлөөгүй байсан зээлдэгч нар зээлээ төлж барагдуулсан.
- Төслийн хугацаанд олж авсан сайн туршлагаа үргэлжлүүлэн, хэвээр хадгалж, ажиллахын тулд сангаас олгох зээлийн хүүгийн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил аргагүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаанд зориулан зарцуулж байхаар жил бүрийн төсөв батлах ИТХ-ын Хуралдаанаар хэлэлцэн баталдаг болсон зөвлөл журам дүрмийн дагуу үйл ажиллагааг тогтвортой, хадгалж явуулсаар байна.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ



Энэ талаар ямар нэгэн бэрхшээл тулгараагүй төслөөс маш сайн чиглүүлж, цаг тухай бүрд арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

СХС-ийн хэлэ 2, 12 оюог жилийн хөрөнгө бөөгдө 8 жил өгдөг болж байгаа хэргийг дунд үйлдвэр эрхлэгч нарыг дэмжих төсөл юм. Энэхүү төсөл суманд хэрэгжсэнээс хойш СХС-ийн хөрөнгө жил ирэх тутам нэмэгдэж байгаа хэдий ч зээлээ зориулалтын дагуу ашигладаггүй, сумынхаа үйлдвэрлэлийг чиглэл чиглэлээр хөгжүүлээгүй, нөхөрлөл хоршоо хэлбэрээр хамтарч хөдөлмөрөө хорших хэлбэрт шилжээгүй, зэргээс авсан санхүүжилт нь төслийн шаардлагад багадсан, эсвэл ихэдсэн, тооцоо судалгаа муутай хийсвэр төслүүдэд санхүүжилт олгодог, олгосон зээлээ эргэж хянах хяналт муу орон тооны бус зөвлөлүүд ажлаа зөв удирдаж, явуулахгүй байгаагаас сүүлийн жилүүдэд хариуцлагагүй зээлдэгч нарын тоо өсөн нэмэгдэж, сум хууль шүүхийн байгууллагад зээлдэгч нарыг шилжүүлж байсан. Энэхүү СХС-ийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, иргэдийн хяналтыг сайжруулж, дээрх үүссэн нөхцөл байдал дахин давтагдахгүй байх талаар арга хэмжээ зохион байгуулж, шинээр барьж ажиллах дүрэм журам боловсруулж гаргасан нь нэн чухал шаардлагатай байсан асуудлыг шийдсэн. **Адаацаг сумын иргэн Г.Лхагва**

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Сумын иргэд сум хөгжүүлэх сангийн талаар мэдлэг, мэдээлэлтэй болсон.

Сум хөгжүүлэх сангийн зээлд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг байгуулснаар сангийн үйл ажиллагаа болон дагалдах хөрөнгө мөнгөний зарцуулалтад иргэдийн зүгээс тавих хяналт сайжирсан.

Хавсралт 1. Журам батлах тухай 30 дугаар тогтоол



ДУНДГОВЬ АЙМАГ
АДААЦАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 30

Тавин

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг, үндэслэн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Журманд заагдсан эрх үүргийг хэрэгжүүлж, ажиллахыг орон тооны бус зөвлөлд даалгасугай.



ДАРГА Г. ТОГТОХБҮРЭН

Хавсралт 2. СХС-ийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөлийн хяналт шалгалт явуулах журам

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2018 оны 12 дугаар сарын 6-ний
өдрийн 30 дугаар тогтоолын хавсралт



**ДУНДГОВЬ АЙМГИЙН АДААЦАГ СУМЫН
СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ,
ЗЭЭЛИЙН АШИГЛАЛТ, ЭРГЭН ТӨЛӨЛТӨД ХЯНАЛТ ТАВИХ ОРОН ТООНЫ БУС
ЗӨВЛӨЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЯВУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, жижиг дунд бизнесийг дэмжих сан /цаашид сан гэх/ нь орон нутагт ард иргэдийн ахуйн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай байгаа бичил жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, энэхүү сангийн үйл ажиллагааны зорилго, зорилтуудын шаардлагыг хангасан үйл ажиллагааг явуулах харилцааг зохицуулж хянахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Сум хөгжүүлэх сангаас зээл авч, төсөл хэрэгжүүлэх жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, хуулийн этгээд энэхүү нийтлэг журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Хяналт шалгалтын зарчим, зорилго, хамрах хүрээ

2.1. Сум хөгжүүлэх сангийн хяналт шалгалт нь хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчимд тулгуурлана.

2.2. Хяналт шалгалтын зорилго нь сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих, сангаас зээл авч, төсөл хэрэгжүүлэх жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа нь Засгийн газрын 153-р тогтоол, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны болон өөрийн гаргасан шийдвэрт нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд чиглэнэ.

2.3. Сангийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, Сангаас зээл авч, төсөл хэрэгжүүлж буй жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг бүрэн хамруулсан байвал зохино.

Гурав. Хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус
зөвлөлийн эрх үүрэг

3.1. Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчээр ахлуулан, Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтэн, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо болон баг тус



бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулан хяналт шалгалтыг гүйцэтгэнэ.

3.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах багийн төлөөллийг тухайн багийн иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлэн сонгох.

3.3. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийн гишүүнийг, сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн гишүүнээр давхар ажиллуулахгүй байх.

3.4. Сум хөгжүүлэх сангийн талаарх тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулан мөрдөж ажиллах

3.5. Хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл нь хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа тухайн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан дараагийн шатанд мэдээллэх

3.6. Хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэх

3.7. Хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл нь дараахь нийтлэг эрх, үүрэгтэй байна:

3.7.1. Зөвлөл зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах;

3.7.2. хяналт шалгалт явуулахдаа сангаас зээл авч, төсөл хэрэгжүүлж буй жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн дарга захиралтай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулах;

3.7.3. илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах

3.7.4. шаардлагатай бол илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар ИТХ-ын Тэргүүлэгчдэд санал тавьж шийдвэрлүүлэх;

3.7.5. Сангийн үйл ажиллагааны талаар ИТХурал, Сумын Засаг дарга үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих

3.7.6. хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

3.7.7. холбогдох дүрэм, журмыг боловсронгуй болгох талаар судалгаа, дүгнэлт гаргах;

Хавсралт 3. Хяналтын чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байгуулах тухай 16 дугаар тогтоол





1. Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

“ИРГЭДИЙН ДУУ ХООЛОЙ БА ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ”**САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ**

Т.НАРАНГАРАВ, “Тогтвортой амьжиргаа 3” төслийн зохицуулагч. Сэтгүүлч, Төрийн Удирдлагын менежер мэргэжил эзэмшсэн. 2012-2016 онуудад Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Засаг даргын тамгын газар орлогч дарга, 2017 оноос “Тогтвортой амьжиргаа 3” төслийн зохицуулагчаар ажиллаж байгаа.

Холбоо барих утас: 80007852, **Цахим хаяг:** munkhsuren0310@gmail.com

АГУУЛГА

“Иргэдийн дуу хоолой ба түүний үр нөлөө” аргачлал нь төрөөс үзүүлж буй үйлчилгээ иргэдэд тэгш чанар хүртээмжтэй хүрч байгаа эсэхийг иргэд өөрсдөө оролцон тодорхойлж, иргэдээс гарсан саналыг шийдвэр гаргах түвшинд хүргэж, иргэдийн оролцоо нэмэгддэгээрээ онцлог юм. Энэхүү аргачлалаар БОЭТ-ийн үйл ажиллагааг сайжруулах зорилготой.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

УИХ-ын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх иргэдийн хандлагын суурь түвшин тогтоох судалгааг 2015 онд 5 аймгийн 15 сум, нийслэл Улаанбаатар хотын 7 дүүргийн 20 хорооны нийт 1200 өрхийг хамарсан судалгаанд оролцогчдын 55% нь ИТХ-ын талаар “Огт мэдэхгүй” гэсэн хариулт өгсөн байдаг.

Удирдлагын академийн доктор, профессор Ш.Батсүх багшаар ахлуулсан судалгааны баг “Орон нутгийн түвшин дэх иргэдийн оролцоо” судалгааг 2014 онд хийсэн бөгөөд тус судалгаагаар “Иргэд орон нутгийнхаа удирдлагын шийдвэр гаргах үйл явцад ямар үүрэгтэйгээр оролцох хүсэлтэй байдаг вэ?” гэдгийг судлахад иргэдийн 75.9 хувь нь буюу 4 хүн тутмын 3 нь орон нутгийнхаа удирдлагын шийдвэрт ямар нэгэн байдлаар оролцох хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байдаг.

Өвөрхангай аймгийн ИТХ-аас сумдын ИТХ-ын үйл ажиллагаанд хийдэг хяналт шинжилгээ, үнэлгээний үеэр сумдын иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгааны сүүлийн 5 жилийн дүн болон 2017 онд Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 11 багийн 200 гаруй иргэдээс иргэдийн оролцооны талаар авсан судалгааны дүнг харьцуулахад судалгаанд оролцсон иргэдийн 50-аас илүү хувь нь НӨУБ түүний үйл ажиллагааны талаар мэдлэг мэдээлэл бага, Нутгийн удирдлагын байгууллагаас иргэдийн оролцоо бүхий хяналтыг хэрхэн бий болгох талаар тодорхой ажил хийдэггүй, шийдвэр гаргах түвшинд иргэд оролцох боломж, мэдлэг муу байдаг гэсэн хариулт өгсөн байна.

Шийдвэр гаргах түвшин дэх иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь аймгийн ИТХ-ын хувьд нэн тэргүүний шийдвэрлэвэл зохих асуудал мөн гэж үзэн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Өвөрхангай аймгийн иргэдийг хамруулсан.



ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2018 оны 1-р сараас 2020 оны 03 дугаар сар хүртэл хэрэгжүүлэв.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

Citizen Voice and Action “Иргэдийн дуу хоолой ба түүний үр нөлөө” аргачлал нь иргэдийн өдөр тутмын амьдралд хамгийн их нөлөө үзүүлдэг төрийн үйлчилгээг сайжруулахын тулд иргэд болон төр хоорондоо харилцан ярилцах замаар нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх аргачлал юм.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- Өвөрхангай аймгийн ИТХ, ДЗМОУБ-тай хамтран төрийн үйлчилгээний чанар хүртээмж ямар байгааг иргэдээр үнэлүүлэх, гарсан шийдвэрт иргэдийн саналыг тусгах, иргэдийн нутгийн удирдлагын байгууллагын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор “Иргэдийн дуу хоолой ба түүний үр нөлөө” аргачлалыг төрийн үйлчилгээний байгууллага болох Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвд хэрэгжүүлсэн.
- Өвөрхангай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “Иргэдийн дуу хоолой ба түүний үр нөлөө” аргачлалыг хэрэгжүүлж зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Тус аргачлалыг хэрэгжүүлсэн 9 сарын хугацаанд ажлын хэсэг 6 удаа хуралдаж, иргэдийг 4 зорилтот бүлэгт хуваан 1800 гаруй иргэдтэй уулзаж, /тусгай аргачлалаар/ иргэдээс гарсан саналыг нэгтгэж ажилласан.
- 2018 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Өвөрхангай аймгийн шийдвэр гаргах түвшний удирдлагууд, иргэдийн төлөөлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний дунд “Нүүр тулсан уулзалт”-ыг зохион байгуулж, тус арга хэмжээний үеэр ажлын хэсгийнхэн иргэдээс гарсан саналуудыг багцлан Өвөрхангай аймаг дахь Бүсийн Оношилгоо эмчилгээний төвийн сайжруулах шаардлагатай 10 ажлын жагсаалтыг танилцуулж, аймгийн удирдлагууд болон иргэд санал солилцож, үйл ажиллагааг сайжруулах ажлын төлөвлөгөөний төслийг хэлэлцэн боловсруулсан.
- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын 10 -ны 62 дугаар тогтоолоор нэг жилийн хугацаанд хэрэгжих 8 зорилт 20 арга хэмжээ бүхий “Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах ажлын төлөвлөгөө”, төлөвлөгөөнд хяналт тавьж ажиллах “Хяналтын баг”-ийн бүрэлдэхүүнийг тус тус баталсан.
- Хяналтын баг Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, төлөвлөгөөний явцын тайланг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 11-ын 28, 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцэж, 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар төлөвлөгөөний биелэлтийг 70 хувьтай хэрэгжсэн гэж эцэслэн дүгнэсэн. Үүнд:
- Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хуралдах өдрийг өөрчилж, пүрэв гарагт болгосон, Амбулаторийн хүлээлгийн хэсгүүдийг тохижуулж, иргэдийг мэдээллээр хангах дэлгэц, электрон самбаруудыг байршуулсан., Цахим бүртгэлийн журамд өөрчлөлт оруулж, үзлэгийн дугаарыг утсаар захиалах боломжийг бүрдүүлсэн ба



үйлчилгээний цагийг уртасгасан, ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэхээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Дэлхийн зөн байгууллага болон ИТХ-ын үйл ажиллагааны санхүүжилтээр шийдвэрлэсэн.

ХҮРСЭН ҮР ДҮН

Өвөрхангай аймгийн ИТХ-аас Иргэдийн дуу хоолой ба түүний үр нөлөө аргачлалыг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрсэн. Үүнд:

- *ИТХ-ын талаар тодорхой ойлголт, мэдээлэлтэй болж, төр иргэний харилцаа сайжирч, шийдвэр гаргах түвшин дэх иргэдийн оролцоо нэмэгдсэн.*
- *Иргэдэд үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирч, иргэдээс ирүүлсэн санал гомдлын тоо буурч улмаар Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвд хийгдэх хөрөнгө оруулалт нэмэгдсэн.*
- *Өвөрхангай аймгийн ИТХ-ын жил бүр иргэдэд үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудад тус аргачлалыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд 2020-2021 онд Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газарт үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.*
- *Аймгийн Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 70321111 утсаар БОЭТ-д хандсан иргэдийн гомдол, санал харьцангуй буурч, 2019 оны эхний хагас жилд 10 иргэний хандалттай байсан бол 3 дугаар улиралд ямар нэг гомдол, санал гараагүй байна.*
- *Тус аргачлалыг сумдад хэрэгжүүлэхэд тохиромжтой үр дүнд хүрэх бүрэн боломжтой гэж үзэн ИТХ-аас сумын онцлогт тохируулан тус аргачлалыг хэрэгжүүлж эхлээд байна.*
- *Иргэд болон нутгийн удирдлагын байгууллага хамтран ажиллаж тодорхой тулгамдсан асуудлыг шийдвэрлэж болдог гэдгийг харуулсан, цаашид олон олон аймаг, сумд салбар бүрд хэрэгжүүлж болохуйц сайн туршлага болно гэж үзэж байна.*